



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 14
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	15 - 51

1.	<i>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	16 - 25
2.	<i>Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	25 - 31
3.	<i>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/</i>	31 - 32
4.	<i>“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	32 - 51

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 33 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

*Томилолттой: С.Бямбацогт, Д.Ганбат;
Чөлөөтэй: Л.Мөнхбаатар, Ж.Сүхбаатар;
Тасалсан: Э.Бат-Амгалан.*

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Монгол Улсын олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц, байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийн санал, дүгнэлт болон “Монгол Улсын олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн хоёр асуудлыг хэлэлцэхийг хойшлуулах санал гаргаж, дээрх хоёр асуудлыг хойшлуулахаар тогтов.

Нэг.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны дэд дарга Б.Батсуурь, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын ахлах мөрдөгч н.Баасанхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга, доктор, профессор Б.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Хуралдаан даргалагчаас хуулийн төсөлтэй холбогдуулан гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Нэг.ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН
ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЪЁОЛОЛ:**

**Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулгын хуралдааны дэгийн тухай хуулийн 42
дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:**

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Н.Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 14.10 дугаар зүйлийн Тайлбарыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11, 12 дахь хэсэг болгох:

“11.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

12.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийг цагдан хорьсон хугацаа нь энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хугацаанд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулгын хуралдааны дэгийн тухай хуулийн 42
дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгасан санал:**

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “6.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын “19.14/Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх/,” гэсний дараа “19.18/Ард нийтийн санал асуулга хууль бусаар явуулах/,” гэж, 20.2/Террорист үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх, хатгах/,” гэсний дараа “20.19 /Улсын онц чухал объект, онц чухал мэдээллийн дэд бүтцийн

байгууллага, байгууламжийн үйл ажиллагаанд саад учруулах/, гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Хоёр.ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:**

**Нэг.Монгол Улсын Их Хурлын чүүлгын хуралдааны дэгийн тухай хүүлийн 42
дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгасан санал:**

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч Н.Баярмаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын Хувийн эрх зүйн хэлтсийн шинжээч М.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал

хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуралдаан даргалагчаас хуулийн төсөлтэй холбогдуулан гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулгын хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:

Д.Цогтбаатар: 1.Ц.Мөнх-Оргил, Н.Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1, 2 дугаар зүйл болгох:

“1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай Долдугаар¹ бүлэг нэмсүгэй:

“ДОЛДУГААР¹ БҮЛЭГ Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа

75¹ дүгээр зүйл.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг

75¹.1.Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75¹.1.1.бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах;

75¹.1.2.дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах;

75¹.1.3.хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах;

75¹.1.4.бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах.

75¹.2. Дараах нэхэмжлэлийг үнийн дүнгээс үл хамааран шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75¹.2.1. шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол;

75¹.2.2. энэ хуулийн 75¹.1.1-д заасан гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл;

75¹.2.3. ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл.

75¹.3. Эрх зүйн нэг маргаанаас үүдэлтэй шаардлагыг хэд хэдэн нэхэмжлэлээр хэсэгчлэн гаргахыг хориглоно.

75¹.4. Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон журмын дагуу шийдвэрлэнэ.

75¹.5. Гэр бүл, өв залгамжлалын холбогдолтой бүх төрлийн хэрэгт тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам үйлчлэхгүй.

75² дугаар зүйл. Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх зарчим, хугацаа

75².1. Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим баримтад тулгуурлан шийдвэрлэнэ.

75².2. Зохигч шүүх хуралдаанаас өмнө, энэ бүлэгт заасан хугацааны дотор өөрийн шаардлага, татгалзлын үндэслэл болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.

75².3. Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

75².4. Энэ хуулийн 75².3-г заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.

75³ дугаар зүйл. Хэрэг үүсгэх, нэхэмжлэл гардуулах

75³.1. Шүүгч энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасан шаардлага хангагдсан бөгөөд энэ хуулийн 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

75³.2.Энэ хуулийн 75⁴ дүгээр зүйлд заасны дагуу хариуцагчид мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ нэхэмжлэлийн хувийг хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын хамт илгээнэ. Хэрэв мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь, эрх, үүргийн тайлбарыг баталгаат шуудангаар илгээсэн, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлснийг энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу хариуцагч хүлээн авсан бол ийнхүү хүлээн авсан өдрөөр, энэ хуулийн 75⁴.4-т заасны дагуу хүргүүлсэн бол мөн зүйлд заасан мэдэгдэх хуудас хүлээн авсанд тооцох өдрийг нэхэмжлэлийн хувийг гардаж авсан өдөр гэж үзнэ.

75³.3.Нэхэмжлэл, хариу тайлбар, хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын загварыг Улсын дээд шүүх батална.

75⁴ дүгээр зүйл.Мэдэгдэх хуудсыг хүргүүлэх

75⁴.1.Шүүх энэ хуулийн 77.2-т заасны дагуу мэдэгдэх хуудсыг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол хариуцагч иргэний болон хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар, эсхүл регистрийн дугаарыг мэдээлсэн нэхэмжлэлийн тухайд албан ёсны хаягийг улсын бүртгэлийн байгууллагаас тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа хийнэ.

75⁴.2.Энэ хуулийн 75⁴.1-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагаас тодруулж ирүүлсэн хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол иргэн, хуулийн этгээдтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний, эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээнэ.

75⁴.3.Энэ хуулийн 75⁴.2-т заасан цахим шуудангийн хаягаас гадна хариуцагчийн албаны болон хувийн цахим шуудангийн хаягийн мэдээллийг нэхэмжлэлд тусгасан бол эдгээр хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг давхар илгээнэ.

75⁴.4.Энэ хуулийн 75⁴.2, 75⁴.3-т заасны дагуу цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш 7 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцно.

75⁵ дугаар зүйл.Хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, гуравдагч этгээд оролцох

75⁵.1.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэгтгэх, тусгаарлах, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд, хамтран нэхэмжлэгч, хамтран хариуцагч татан оролцуулах ажиллагаа хийгдэхгүй.

75⁵.2.Хариуцагч нэхэмжлэлийг гардаж авснаас хойш 7 хоногийн дотор сөрөг нэхэмжлэл гаргаж болно.

75⁵.3.Сөрөг нэхэмжлэл энэ хуулийн 73, 75¹ дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

75⁵.4.Зохигч үндсэн ба сөрөг нэхэмжлэлийг гардан авснаас хойш 5 хүртэл хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй.

75⁵.5.Нэхэмжлэгч иргэний хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасан шаардлага, үндсэн нэхэмжлэлд заасан үндэслэлийн хүрээнд нэхэмжлэлийн шаардлагаа нэг удаа нэмэгдүүлж болно. Нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлснийг хэргийн оролцогчид мэдэгдэнэ.

75⁵.6.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдын эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр оролцож болно.

75⁶ дугаар зүйл.Гэрчийн мэдүүлэг

75⁶.1.Гэрч энэ хуулийн 43.3-т заасан эрх, үүргийг ойлгосны үндсэн дээр үнэн зөв мэдүүлснээ илэрхийлэн, нотариатаар гэрчлүүлсэн мэдүүлгийг шүүхэд ирүүлсэн нь хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75⁶.2.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн тусламжтай гэрч, шүүгч, зохигч нэгэн зэрэг холбогдон авсан гэрчийн мэдүүлгийг хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75⁶.3.Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлсэн нь гэрчийн мэдүүлгийг энэ хуулийн 75⁶.2-т заасны дагуу үнэлэхэд саад болохгүй.

75⁷ дугаар зүйл.Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэх

75⁷.1.Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш дараах нөхцөл байдал тогтоогдвол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай захирамж гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ:

75⁷.1.1.нэхэмжлэл гаргах, эсхүл иргэний хэрэг үүсгэхдээ энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасныг зөрчсөн;

75⁷.1.2.тухайн хэрэг нь эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байж болзошгүй гэж үзсэн.

75⁷.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй.

75⁷.3.Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс тогтоосон тов ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хүчинтэй хэвээр байна.

75⁷.4.Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр үргэлжлүүлсэн нь хэрэг хянан шийдвэрлэх хугацааг шинээр тоолох үндэслэл болохгүй.

75⁸ дугаар зүйл.Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх

75⁸.1.Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш энэ хуулийн 74.1-д заасан үндэслэл бүрдвэл хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэнэ.

75⁹ дүгээр зүйл.Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр

75⁹.1.Энэ хуулийн 75⁷.1-д зааснаас бусад тохиолдолд шүүх энэ хуулийн 75¹.1, 75¹.2-т заасан хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх хуралдаанаас шийдвэр гаргана.

75⁹.2.Энэ хуулийн 75⁹.1-д заасан шийдвэр нь удиртгал, үндэслэх, тогтоох хэсэгтэй байх бөгөөд үндэслэх хэсэгт нэхэмжлэлийн шаардлага, татгалзал, шийдвэрийн үндэслэлийн товч агуулгыг дурдана.

75⁹.3.Шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ хуулийн 119 дүгээр зүйлд заасны дагуу зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулна.

75⁹.4.Энэ хуулийн 75⁹.2 дахь хэсэг давж заалдах шатны шүүхийн магадлалд нэгэн адил үйлчилнэ. Шийдвэр, магадлалын бүтэц, боловсруулах аргачлалыг Улсын дээд шүүх батална.

75¹⁰ дугаар зүйл.Шүүхийн шийдвэрээр нэмэлт хугацаа тогтоох, хуваарь гарган хэсэгчлэн төлөх

75¹⁰.1.Нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн, эсхүл хэсэгчлэн хангасан бол хариуцагчийн санхүүгийн байдал, харгалзвал зохих бусад зайлшгүй шалтгаанаар, хариуцагчийн хүсэлтэд үндэслэн шийдвэрийг биелүүлэх нэмэлт хугацаа тогтоох, эсхүл хуваарийн дагуу хэсэгчлэн төлөхөөр шүүхийн шийдвэрт зааж болно. Нэмэлт хугацаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш зургаан сараас илүүгүй байна.

75¹¹ дүгээр зүйл.Давж заалдах гомдол гаргах

75¹¹.1.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 75⁹.3-т заасны дагуу гардуулснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

75¹¹.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хуулийн төслийн талаар ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

**Дөрөв. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны дэд дарга Б.Батсуурь, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын ахлах мөрдөгч н.Баасанхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга, доктор, профессор Б.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Ш.Раднаасэд, Б.Энхбаяр, Б.Дэлгэрсайхан, Б.Энх-Амгалан, Ш.Адъяаа, Н.Алтанхуяг, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан дараах асуудлыг судлан холбогдох хуулийн төслийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцүүлэн боловсруулж 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-г даалгасугай:

1/хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, эсхүл түүнээс гэрчийн мэдүүлэг авахгүй байх, гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол гэрчийн мэдүүлэг авахыг даруй зогсоох зохицуулалтыг тусгах;

2/хүний халдашгүй байх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хүрээнд мөрдөн байцаалтыг өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр явуулахгүй байх, хэрвээ өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр мөрдөн байцаалт явуулж нотлох баримт цуглуулсан, хэрэг хүлээлгэсэн тохиолдолд тухайн мэдүүлэг, нотлох баримтыг үнэлэхгүй байх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

3/шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулдаг үндэслэл, нөхцөл боломжийг бий болгож байгаа хуулийн хийдлийг судалж, түүнийг арилгах, зохицуулалтыг боловсронгуй болгох;

4/олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тогтоохтой холбогдсон зохицуулалтыг хуульд тусгах;

5/хавтаст хэргийг цахимжуулах, цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаанд шинжлэн судлах, цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх журмыг боловсронгуй болгох;

6/төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүх, прокурорын шийдвэрийг оролцогчид танилцуулах, гардуулан өгөх журмыг нарийвчлан зохицуулах;

7/шинээр нэгтгэсэн хэрэгт цагдан хоригдсон хугацааг тусад нь тоолох журмыг боловсронгуй болгох;

8/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах нөхцөл боломжийг бий болгох, 6-аас дээш сар хадгалах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

9/Өмгөөллийн тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх, үүргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмж тусгах;

10/сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон үндэслэлд хамаарах нотлох баримттай танилцах, таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн

хэлэлцүүлгийг талуудын мэтгэлцээний үндсэн дээр явуулах зохицуулалтыг боловсронгуй болгох;

11/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг сайжруулах, хэргийн оролцогчийн эрхийг хангаснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараагийн шатанд хэргийг шилжүүлдэг зохицуулалтыг тусгах;

12/мөрдөгч, прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан яллагдагч, шүүгдэгчийг цагаатгах, хэргийг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг нотлох чиг үүргээ хэрэгжүүлээгүй бол яллагдагч, шүүгдэгч энэ талаарх нотлох баримтыг шүүхэд гаргах эрхийг хуульд тусгах;

13/хүн ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхийг хангах хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан талаарх тогтоолыг гардуулан өгөх зохицуулалтыг хуульд тусгах;

14/шүүх, прокурор, мөрдөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хүсэлтийг хангахаас татгалзаж байгаа үндэслэлийг тухайн шийдвэртээ тодорхой тусгах асуудлыг хуульчлах.

2.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хороо, Эрүү шүүлтийн эсрэг хорооноос гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүхийн тогтолцоог бүрдүүлэх талаар судалж Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмжтэй холбоотой зардлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

5.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 54 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
10 цаг 33 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдаанд ирсэн гишүүд. Дамдины Цогтбаатар, Ширнэнбаньдийн Адьшаа, Ганибалын Амартүвшин, Норовын Алтанхуяг, Борхүүгийн Дэлгэрсайхан, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Бөхчулууны Пүрэвдорж, Шатарбалын Раднаасэд, Цэндийн Сандаг-Очир, Ням-Осорын Учрал, Баттөмөрийн Энхбаяр, Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Цэндийн Мөнх-Оргил гишүүн гэсэн гишүүд ирсэн байна.

Ц.Сэргэлэн гишүүн бас ирсэн байна. Тийм. Цэдэвийн Сэргэлэн гишүүн ирсэн байна.

Ингээд Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр хэлэлцэх зургаан асуудал байгаа.

Нэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.

Засгийн газар 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн байгаа.

Энэ одоо эцсийн хэлэлцүүлэг хийгдэх гэж байна.

Хоёр. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн байгаа. Бас эцсийн хэлэлцүүлэг.

Гурав. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл. Анхны хэлэлцүүлэг.

Дөрөв. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Тав. Монгол Улсын олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц, байдалтай танилцах, санал,

дүгнэлт боловсруулах ажлын хэсгийн санал, дүгнэлтийг авч хэлэлцэнэ.

Зургаа. “Монгол Улсын олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн ийм зургаан асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Саналаа өгнө үү. Ц.Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Хэлэлцэх эсэх асуудлын жагсаалтаас тав, зургадугаар асуудлыг өнөөдөр хасаж өгөөч ээ гэсэн хүсэлтэй байна.

Өчигдөр ажлын хэсэг хуралдаад бэлдсэн материалууд маань Их Хурлаар хэлэлцүүлэх шаардлага хангаагүй байна.

Ялангуяа яам, Тамгын газраас ирүүлсэн олон улсын олон талт нэгдэж орсон гэрээ, хэлэлцээрүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хавсралтын материалууд нь дутуу байгаа учраас хаврын чуулганаар хэлэлцүүлье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Нэгэнт бэлэн биш байгаа юм бол энэ асуудлыг хэлэлцэх асуудлын жагсаалтаас хаслаа. /алх цохив/

Хоёр асуудал хаслаа шүү дээ.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн мэдүүлсэн хуулийн төсөл
/Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг хийе.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их

Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулна.

Ц.Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг

хангах ажлын хэсэг хуралдсан. Мөн ажлын дэд хэсэг хамтарч хуралдсан.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу санал хураалгах нэг санал, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу санал хураалгах хоёр заалт тус тус байна.

Чуулганы нэгдсэн хуралдааны үеэр хурал даргалагчаас дахин боловсруулах чиглэл өгсөн.

Ажлын хэсгийн гишүүд санал нийлсэн. Ажлын дэд хэсгийн гишүүдийн санал нийлсэн.

Техникийн шинж чанартай гурван заалт байгаа.

Мөн “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг ажлын хэсэг боловсруулж Байнгын хорооны гишүүдэд тараасан байгаа.

Тогтоолын төслийг баталж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Тэгэхээр хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Батаагийн Батцэрэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Батзэвэгийн Энхболд, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатын шүүхийн шүүгч Л.Галбадрах ирсэн байна уу? Ирээгүй байна.

Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх Максимын Чинбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Ганзоригийн Эрдэнэбулган, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны дэд дарга, цагдаагийн хурандаа Баттөмөрийн Батсуурь, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын ахлах мөрдөгч н.Баасанхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон, Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга, доктор, профессор Бадамын Батзориг нар оролцож байна.

Танилцуулгатай холбогдон асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү?

Б.Энх-Амгалан гишүүнээр тасаллаа.

Ш.Адъяаа гишүүний микрофоныг өгье.

Ш.Адъяаа: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль үндсэндээ батлагдах эцсийн хэлэлцүүлэг явагдаж байна л даа.

Тэгэхээр энд олон асуудлыг хамарсан, ялангуяа мөрдөх байгууллага, прокурорын гэмт хэргийг илрүүлэх, сэжигтнийг шалгахтай холбоотой зохицуулалт чинь би анхнаасаа л их бүрхэг байна гэдэг байр суурьтай байсан. Одоо ч гэсэн энэ асуудал ингээд батлагдлаа. Үүнийг би протоколд тэмдэглүүлж байгаа юм. Зүгээр үг хэлэх гэж байгаа юм.

Тэгээд шүүх эрх мэдлийг бүх юмыг шүүхийн хэмжээнд авч явах, шүүхээр бүх асуудлыг шийдүүлэх зарчим үйлчлэх ёстой. Үүнтэй санал нэг байгаа.

Гэтэл өнөөгийн нөхцөл байдал, эрүүгийн хэрэг хянан шалгах, эрүүгийн нөхцөл байдал. Үүнтэй холбогдуулж Засгийн газраас оруулж ирсэн хууль чинь нэлээн олон эрсдэл, нэлээн олон асуудал дагуулах нь тодорхой байна. Тодорхой байна. Ингээд цаг хугацаа харуулна биз.

Ийм байдлаар бид өнөөдөр шүүх эрх мэдэл, мөрдөн байцаах байгууллага, түүнчлэн хүний эрхтэй холбоотой асуудал, гэмт хэргийг илрүүлэхтэй холбоотой асуудал, мөрдөх байгууллагын эрх үүрэг, түүнд хяналт тавьдаг прокурорын байгууллагын эрх үүргийг хоёрдмол утгаар оруулж ирж байгаа нь өнөөдөр нэг их сайн үр дүн авч ирэхгүй байх л гэж бодож байгаа. Сайн үр дүн авч ирэхгүй байх гэж бодож байна.

Ийм учраас асуудал нэгэнт олонхын шийдвэр гаргаад, Засгийн газар өнөөдөр өргөн бариад ингээд шийдэж байгаад би цөөнхийн байр суурь дээр л байгаа. Дахиад ч би цөөнхийн байр суурь дээр байна.

Үүнийг ер нь цаашлаад хүний эрхтэй холбоотой, гэмт хэрэг мөрдөх, шалгахтай холбоотой асуудал дээр ийм байдлаар өнөөдөр орж ирээд явбал энд гэмт хэргийн илрүүлэлт, гэмт хэрэгтэй тэмцэх Засгийн газрын чинь үүрэг ямар тал руугаа яваад байна гэдэг ийм бодолтой байгаа.

Ийм учраас үүнийг хууль санаачлагч болон энд хүмүүс асуух юм алга. Зүгээр би протоколд тэмдэглүүлээд энд үг хэлж байгаа юм.

Тэгээд Улсын Их Хурлын тогтоолтой холбогдуулаад асуулт асууж болох юм уу? Болно тийм ээ.

Тэгэхээр хууль батлагдсантай холбогдуулж Улсын Их Хурлын тогтоол гарах юм байна.

Тэгэхээр хууль санаачлагчаас би хоёр, гурван асуулт асууя. Ингээд мөрдөх байгууллага ер нь гэмт хэрэг илрүүлэхдээ эхлээд гэрчээр байцаадаг практик байсан. Үүнийг нь гэрчээр байцаах асуудлыг нь байхгүй болгож байгаа гэж ойлголоо.

Тэгэхээр гэрчээр байцааж байгаад тэгээд гэнэтхэн сэжигтэн, яллагдагч болоод л тэгээд гэмт хэрэгтэн гэдэг тийм ойлголт руу явж байсан практикийг халах чиглэлийг Улсын Их Хурлын тогтоолоор өгч байгаа юм байна.

Үүнийг хуульдаа яагаад оруулаагүй вэ? Дахиад хууль санаачилж оруулж ирэх юм уу? Одоо энэ чинь өнөөдөр гэрч.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ажлын хэсгийн дарга Ц.Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Ш.Адъяаа гишүүний асуултад хариулъя.

Хүнийг шаардлага гарвал гэрчээр байцаадаг хэвээрээ л дээ.

Тэгэхдээ гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрчхээд байдаг, илт болчихоод байдаг. Тэгээд байхад нь мэдсээр байж гэрчээр дуудчихаад, баахан мэдүүлэг авчхаад, тэгээд сэжигтэн болгочихдог энэ процессыг л зохицуулья гэж байгаа юм. Халъя гэж байгаа юм.

Сэжигтнээр байцаалт авах үндэслэл байгаа бол гэрчээр байцаахгүй

шүү. Шууд хэлээд, сэжигтнээр нь байцаа гэдэг. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ бол нэлээн газар авсан практик. Тэгээд миний ойлгосноор Монгол Улсын Дээд шүүхээс энэ дээр тайлбар гаргасан юм уу? Б.Батцэрэн шүүгч ээ. Тайлбар гаргасан юм билээ.

Тэгээд тэр тайлбарын ерөнхий санаа, агуулгыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт болгоод оруулаад ир гэдэг үүргийг Засгийн газарт өгч байгаа юм. Хугацаатай үүрэг.

Яагаад ажлын хэсэг үүнийг шууд хуульдаа хуулийн нэмэлт оруулчихаж болохгүй байна вэ гэвэл Засгийн газраас өргөн барьсан хуульд хөндөгдөөгүй заалт учраас дэгээрээ ийм заалт санаачилж оруулах боломжгүй болчихоод байгаа юм.

Д.Цогтбаатар: Ш.Адьяа гишүүний микрофоныг өгье. Тодруулж асууя.

Ш.Адьяа: Энэ бас их зөв асуудал оруулж ирсэн. Их Хурлын тогтоолын төсөл дээр байгаа юм байна.

Тэгэхээр сэжигтэн яллагдагчид ч биш, энэ гэрчээр дуудаад л, сүүлд нь ингээд л практикийг халах нь өнөөдөр зөв өө. Хүний эрхийн талаасаа.

Дээр нь өнөөдөр тэр Үндсэн хуульд заасан өөрийнхөө гэр бүлийн эсрэг мэдүүлэг өгөхгүй гэдэг. Өөрийнхөө хамгийн ойр дотно хүнийхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй гэдэг ийм Үндсэн хуулийн зарчим байдаг хэдий ч мөрдөх байгууллага, бусад шалгах, гүйцэтгэх ажиллагаа явуулдаг хүрээнд энэ Үндсэн хуулийн чинь зарчим угаасаа алдагдсаар ирсэн.

Энэ дээр давхар энэ асуудлыг оруулж ирэх асуудал байна уу? Цаашдаа яах юм? Одоо ингээд эхнэр, нөхөр хоёрын хүүхдийг нь аваачаад ингээд заавал мэдүүлэг авах гээд шалгадаг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ажлын хэсэг, Хууль зүйн сайд. Б.Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Энэ хуулийг дагалдаж гарч байгаа тогтоолын төслийг Засгийн газар талархан хүлээн авч Улсын Их Хурлаас өгсөн бодлого, чиглэлийн хүрээнд хууль тогтоомжийн төслийг боловсронгуй болгох ажил дээр Хууль зүйн яамны дэргэдэх байнгын ажлын хэсгийн хүрээнд судалж авч үзнэ.

Энэ бол шинэ асуудал биш. Олон жил яригдаж байгаа. Миний тухайд ч гэсэн ер нь олон удаа энэ асуудлыг явсаар ирсэн.

Ялангуяа үндэслэл бүхий шууд гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл нөхцөл байдал байсаар байхад тухайн этгээдийг эхлээд гэрч байдлаар асуугаад, дараа нь гэрчээр өгсөн мэдүүлгийг өөрийнх нь эсрэг ашигладаг. Энэ нь өөрөө Үндсэн хуулийн үзэл баримтлалын эсрэг юм.

Яагаад гэхээр өөрөө өөрийгөө өмгөөлөх, өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх үндэс.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр гишүүнд микрофоныг гүйцээгээд өгье. Гүйцээгээд хариулчихъя. Гүйцэд хариулсан нь дээр.

Б.Энхбаяр: Хүн өөрөө өөрийгөө өмгөөлөх, өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх Үндсэн хуульд заасан үндсэн эрхтэй байдаг.

Тэгтэл тухайн гэрч байдлаар асуугаад, гэрч нь болохоор худал мэдээлэл өгөхгүй байх үүрэгтэй байдаг. Худал мэдээлэл өгсөн тохиолдолд Эрүүгийн хуулийн хариуцлагатай.

Тэгэхээр хууль сануулж байгаад худлаа ярьж болохгүй шүү, хуулийн хариуцлагатай гэдэг байдлаар мэдүүлгийг нь аваад, тэгээд өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх тэр үндсэн эрхтэй нь зөрчилдсөн байдлаар мөрдөн шалгах ажиллагааг явуулах нь өөрөө Үндсэн хуулийн бус, хүний эрхийг дордуулсан байдлаар гэмт хэргийг шалгах ажиллагаа нөлөөлөөд байгаа юм.

Үүнийг хууль тогтоомжийн хүрээнд яг яаж бичих вэ гэдэг бол бас нэлээн нарийн чимхлүүр ажил байгаа. Бид үүнийг нэлээн, хоёр, гурван хувилбараар бас оролдож үзэж байгаа юм. Судалгааны түвшинд.

Шууд хүнийг гэрчээр асууж болохгүй ээ гээд шууд бичих гэхээр дөнгөж гэмт хэрэг гарчихсан, сэжиг таамаг бүхий нөхцөл байдал дээр дөнгөж хэргийн газар дээр очиж байгаа хүн энэ хүн бол шууд гэмт хэрэгтэн байна гэдгийг харц мэдрэмжээрээ хэлж байгаа тэр нөхцөл байдлыг хуульд шууд тодорхойлох боломж их багатай.

Тийм учраас үүнийг яах вэ нэлээн тийм процесстой, хяналттай байдлаар бичих.

Хэрвээ магадгүй хоёр, гурван хувилбар байгаа юм. Гэрчээр асуучихсан. Хэрэв сэжигтэн яллагдагчаар татчихаж байгаа бол гэрчээр асуусан тэр мөрдөн байцаалтад мэдүүлсэн мэдүүлгийг нь цаашид нотлох баримтаар үнэлэхгүй, ашиглахгүй гэдэг бас хувилбар байгаа юм. Ингээд хоёр, гурван янз байна.

Гэтэл яг анх гэрчээр асууж байх үед тухайн хүнийг гэмт хэрэгтэн, хэрэг хийчихсэн юм гэж хэн ч мэдээд байгаа юм бас байхгүй. Тэгээд л бүгдийг нь л гэрчээр асууж байх үеийн нөхцөл байдал байхгүй юу.

Тийм учраас энэ бол яг хууль хэрэглээн дээрээ хууль зүйн хувьд бас нэлээн чимхлүүр нарийн асуудал. Үүнийг хэр зөв тогтоохоос хамаараад. Хэрвээ бид буруу хуулийн томъёолол биччихвэл магадгүй гэмт хэрэгтнүүдэд ял завшуулчихна. Нөгөө гэрчийн мэдүүлгүүдийг ерөөсөө нотлох баримтаар үнэлэхгүй гэхихдэг. Анх хэрэг учрал гарах үеийн халуун байх үеийн яриа хөөрөө дээр чухал үнэлэх мэдүүлгүүд өгөгдсөн байдаг ч юм уу.

Тийм учраас үүнийг яг хууль хэрэглээн дээр бид нэлээн бодож байж шингээх асуудлыг Ш.Адъяаа гишүүн маань хөндөж тавьж байна. Анхаарч ажиллана.

Д.Цогтбаатар: Б.Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Б.Энх-Амгалан: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг дэмжиж байгаа.

Өмнө нь хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг ч бас дэмжиж байна.

Тэгээд би хоёр, гурван санал хэлэх гээд байгаа юм.

Өмнө нь би бас хэлж байсан. Мэдээлэл байгаа гэдэг үндэслэлээр аваачаад хорьдгоо болиорой гэж.

Тэгээд үүнийг протоколд хуулийн ажлын хэсгийн ахлагч Ц.Мөнх-Оргил гишүүн маш тодорхой хэлээд.

Энэ бол хэвлэлээр гарсан, сайтаар гарсан ямар нэгэн тийм мэдээлэл биш шүү. Энэ бол дараа нь **“нотлогдох ёстой мэдээлэл шүү”** гэдэг асуудлаар протоколд үлдээсэн шүү.

Хууль хэрэглэхдээ яг үүнийг анхаарна шүү. Тэр мэдээлэл дараа нь нотлогдохгүй бол мэдээлэл байгаа гэдэг үндэслэлээр аваачиж хорьчихоод тэгээд тэр хүнээ гаргадаггүй ингээд хорьчихдог байж огтхон ч болохгүй.

Тэгээд л байлгаад байдаг, сунгаад л байдаг. Энэ бол хүний эрхэд халдаж байгаа их ноцтой асуудал байхгүй юу.

Тэгэхээр үүнийг нэгдүгээрт анхаарах ёстой. Хууль хэрэглэхдээ үүнийг онцгой анхаараарай гэдгийг нэгдүгээрт би яг хууль батлагдах гэж байгаа энэ үед хэлмээр байгаа юм.

Хоёр дахь асуудал. Өмнө нь одоо ингээд Засгийн газраас орж ирсэн хувилбар дээр өмгөөлөгчид нь мэдэгдээд, тэгээд шүүхэд шилжүүлчихдэг ч байдаг юм уу, яллагдагчаар татчихдаг ч байдаг юм уу ийм асуудал байдаг байсан.

Тийм учраас энэ бол өмгөөлөгчийг бүх шатад нь оролцуулна, хэргийн материалтай танилцуулна гэдэг ийм асуудал дээр орсон шүү гэдгийг бас хэлье.

Тэгэхгүй бол очоод ингээд материалтай танилцах гээд нэг их олон хавтас санхүүгийн тайлан аваачиж тавьчихаад тэгээд наадхыгаа хуулж ав гээд суугаад байдаг. Тэрийг чинь яаж хуулж авах юм бэ. Тэр богино хугацаанд. Эсвэл

өдөржин ганцаараа сууж хуулж авах юм уу. Зүгээр зургийг нь дараад, дараад хэрэгтэй материалаа авчихдаг байж болно шүү дээ.

Тийм учраас өмгөөлөгчийг тэр хэргийн бүх шатад оролцуулах, хэргийн материал танилцуулах асуудал хууль дээр ингэж орсон шүү гэдгийг яг өмнөх хурал дээр би асууж байгаад тэрийгээ протоколд үлдээсэн учраас би үүнийг бүр тодотгож хэлж байгаа юм.

Тэгээд цаашдаа яах вэ тэр хууль хэрэглээнийхээ явцад бас Засгийн газраас өргөн барьчихсан учраас наадах чинь нөгөө процедуроороо үүнийг чинь шууд өөрчилж болохгүй зарим заалтууд байгаа юм.

Үүнийг тэгээд Засгийн газар, Хууль зүйн сайд, хууль санаачлагчид анхаарна биз.

Би дээр нэг ийм юмыг бас хэлэх гээд байгаа юм. Энд гардаг нэг тодорхой нэг жишээ байна л даа.

Гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрөхгүй байгаа холбогдох хэргийг бүхэлд нь ердийн журмаар хянан шийдвэрлэж болно. Энэ 8 дээр байгаа юм шүү. 5 дугаар бүлгийн 17.2 дугаар зүйлийн 8 дээр байгаа юм. 9 дээр нь байгаа юм.

Гэм буруугаа бүрэн, эсхүл хэсэгчлэн хүлээн зөвшөөрөөгүй бол тухайн яллагдагчид холбогдох хэргийг ердийн журмаар шийдвэрлэнэ.

Тэгсэн хэрнээ гэм буруугаа хүлээн зөвшөөрөөд хамтран ажиллачихсан бол хялбаршуулсан журмаар шийдвэрлэнэ.

Нэг ёсондоо гэм буруугаа хүлээн зөвшөөрөхгүй бол тэр нөхрийг ингээд

ердийн журмаар шийдвэрлэж асуудалд оруулчхаад тэгээд худлаа үнэн хэрэг хүлээчихсэн хүнийг бол за яах вэ, чамайг тэгвэл одоо ингээд хялбаршуулсан журмаар шийдвэрлэе гэдэг ийм рүүгээ орчих ийм магадлал өндөр байна шүү.

Одоо бол яг үүнийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэнэ гэдэг нэг заалт манай Х.Нямбаатар хуульд оруулчихсанаас болоод нөхдүүд хэрэг наймаалцдаг болчихоод байгаа юм. Очоод шууд тэгсэн, тэгсэн гээд худлаа мэдүүлэг өгөөд ингэчихдэг ийм алхам руу орж байна лээ шүү.

Тийм учраас үүнийг цаашдаа нэлээн онцгой анхаарч энэ асуудал дээр тийм худал мэдүүлэг өгөх, сүүлд нь тэр гэрчээр өгсөн мэдүүлэг янз янзын юмнууд нь батлагдахгүй хялбаршуулсан журмаар хэрэг шийдүүлэх гэж ингэж явсан бол энэ сүүлдээ асуудалд ордог байх ёстой. Ийм нэг асуудал байгаа юм.

Ер нь тэгээд цаашдаа бас нэг юмыг бид бодохгүй болохгүй. Үүнийг тэгэхдээ бид хаврын чуулганд барьж чадах нь уу, чадахгүй нь уу.

Хэлмэгдчихсэн хүн одоо яах вэ, тэгээд төр хэлмэгдсэнийг нь цагаатгадаг юм байж. Хэлмэгдүүлчихсэн хүнийг тэгвэл яах юм?

Д.Цогтбаатар: Гишүүн ээ. Энэ дагаж мөрдөх журамтай холбоотой тэр асуудал дээрээ уг нь яриад явчихвал.

Харин тэгэхээр тэгж протоколд үлдэнэ шүү дээ. Тэгэхгүй бол наадах чинь яг хэлэлцэж байгаа асуудлаас төөрчхөөд байгаа байхгүй юу.

Гэхдээ нэгэнт та асуучихсан юм чинь гүйцээгээд микрофоныг нь өгчихье. Та гүйцээгээд.

Б.Энх-Амгалан гишүүний микрофоныг өгчихье. Гэхдээ би гишүүддээ нэг юм сануулья. Яг хэлэлцэж байгаа, хэлэлцэж байгаа асуудлаараа яримаар байна. Тэгэхгүй бол хэлэлцүүлэг төөрчихнө шүү дээ.

Б.Энх-Амгалан: Үгүй ээ, үгүй. Энэ бол нөгөө Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Их Хурлын тогтоолтой л холбоотой асуудал шүү дээ.

Тийм учраас хуультайгаа холбоотой байхгүй юу. Хуультайгаа холбоотой учраас би цааш нь хууль хэрэглээн дээрээ үүнийг анхаараарай. Нэмж заалтууд оруулж ирэх хэрэгтэй байна шүү. Ийм ийм зөрчил дутагдал гарч байна шүү. Хүний эрхийн зөрчил, дутагдлууд. Үүнийг анхаараарай л гэсэн юм хэлж байгаа юм.

Тэгээд яваандаа хүний эрхийг зөрчсөн иймэрхүү асуудлууд гарвал, хүнийг хэлмэгдүүлсэн асуудал гарвал тэндээ тодорхой хариуцлага тооцдог ийм юм оруулж ирэхгүй бол бас болохгүй юм билээ гэдгийг л давтаж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Ингээд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг гишүүдэд тараасан байгаа.

Тэгээд хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгөх үү? Асуулт асуучихсан.

Тэгвэл хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны

үеэр хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу.

Одоо энэ дээрээ гурван санал байгаа шүү дээ. Тийм. Гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Гурван зарчмын зөрүүтэй санал байгаа.

Энэ дээр гишүүддээ нэг юм хэлэхэд гуравны хоёроор босно шүү.

Тэгэхээр гишүүд маань анхааралтай саналаа өгөөрэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулгын хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 14.10 дугаар зүйлийн Тайлбарыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11, 12 дахь хэсэг болгох:

“11.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

12.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийг цагдан хорьсон хугацаа нь энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хугацаанд хамаарахгүй.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Н.Алтанхуяг,

Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж,
Ш.Раднаасэд. Цаашид ажлын хэсэг гэх.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулгын хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгасан санал:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “6.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын “19.14/Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх/,” гэсний дараа “19.18/Ард нийтийн санал асуулга хууль бусаар явуулах/,” гэж, 20.2/Террорист үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх, хатгах/,” гэсний дараа “20.19 /Улсын онц чухал объект, онц чухал мэдээллийн дэд бүтцийн байгууллага, байгууламжийн үйл ажиллагаанд саад учруулах/, гэж,” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя.

Ш.Адьшаа гишүүнийг дэмжсэнээр оруулаарай. Тооцоорой.

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулгын хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дэх заалтын дагуу хураалгасан санал:

1.Төслийн 3 дугаар зүйлийг хасах.

Санал хураалт явуулья.

84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хураалтыг явууллаа.

Ингээд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулна.

Ц.Мөнх-Оргил гишүүнд микрофон өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа.

Засгийн газраас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай чухал дэвшилттэй заалтуудыг өргөн мэдүүлснийг манай Хууль зүйн байнгын хороо, түүнээс байгуулагдсан ажлын хэсэг, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлсэн ажлын дэд хэсгийнхэн идэвхтэй сайн хариуцлагатай ажиллаж хэлэлцэж, анхны хэлэлцүүлгийг дуусгасан. Одоо эцсийн хэлэлцүүлгийг хийгээд ингээд нэгдсэн хуралдаанд оруулах гэж байна.

Тэгээд нэгдсэн хуралдаан дээр би талархсан үгээ хэлж, нэгдсэн хуралдааны цаг авахгүйн тулд Байнгын хороон дээрээ Байнгын хорооныхоо гишүүдийн өмнөөс

болон хувиасаа ажлын дэд хэсэгт орж ажилласан нийт гишүүдэд, тухайлбал Дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн, прокурорын орлогч прокурор М.Чинбат, О.Мөнхбаатар прокурор, Хүний эрхийн комиссын гишүүн Б.Энхболд, Б.Батзориг судлаач, Х.Энх-Ундрэм, манай цагдаагийн Б.Батсуурь хурандаа. Хүн амьтан үлдээгээгүй биз.

Өмгөөлөгчдийн холбооны Л.Данзанноров, Д.Батсүх өмгөөлөгч нар оролцсон.

Хүн үлдээсэн бол уучлаарай. Бүгдээрээ маш идэвхтэй оролцож, манай дэд ажлын хэсэг нийт 11 удаа хуралдсан. Гишүүд ээ, 11 удаа хуралдсан.

Энэ танхимд бид 8 удаа хуралдсан, прокурор дээр 2 удаа, Дээд шүүх дээр 1 удаа маш олон асуудлуудыг тал талаас нь ярьж мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлсэн.

Мөн Улсын Их Хурлын дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх н.Эрдэнэбат бас идэвхтэй оролцож, дэмжлэг туслалцаа үзүүлсэн. Манай Тамгын газрынхан оролцсон. Тэр бол нөгөө Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ажлын хэсгийнхэн сууж байгаа.

Бүгдэд нь их баярласнаа хэлчихье. Баярлалаа. /алга ташив/

Д.Цогтбаатар: Ямар ч гэсэн нээрээ энэ дээр их идэвхтэй ажилласан би бас ажлын хэсэгтээ талархал илэрхийлмээр байна. Ц.Мөнх-Оргил сайдад.

Ер нь иргэний болон эрүүгийн процессын хууль амаргүй хууль орж ирсэн. Засгийн газар дээр энэ бас нэлээн идэвхтэй ажилласан.

Би энэ дээр нэг зүйлийг хэлмээр байна.

Манай хууль хяналтын байгууллагынхан. Дараа нь дагаж мөрдөх журамтай холбогдуулаад орж ирж байгаа хууль тогтоомжууд дээр нэг зүйлийг оруулж өгөхөөр хэдүүлээ ажиллаж байгаа. Үүнийг Та нар шат шатандаа дэмжээд, доор доорх байгууллагууддаа нэг юм ойлгуулах ёстой.

Энэ процесст өмгөөлөгчдийн оролцоо, эд нарын статусыг жинхэнэ ажил хэрэг дээрээ нэмэх ёстой шүү.

Хэдүүлээ одоо эндээ ингээд л аягүй гоё зөв юм яриад, амьдрал дээр хэрэгжээд эхлэхлээрээ өмгөөлөгчтэй чинь ярихгүй, ингтэгнэ гээд өмгөөлөгчдийг бараг ер нь энэ ямар хамаа байсан юм. Би төр байна гэсэн ийм хандлагатай бодит практик дээр дутагдлууд байгаад байгаа.

Хэдүүлээ үүнийг энд засъя л гээд хийж байгаа юм чинь. Үүнийгээ дараа нь амьдрал дээр ажил хэрэг болгох тал дээр

хэдүүлээ бас их сайн анхаарч ажиллах ёстой шүү.

Энэ удаагийн өөрчлөлтүүдийнхээ гол ололтыг нь шүүх дээр ч гэсэн мэтгэлцэх зарчим өөрөө дараагийн шатдаа хүрч, мэтгэлцэж, хэн хэрэг дээрээ илүү ажиллаж, нотлох баримт цуглуулж, хараагүй өнцгүүдийг харж, хуулийн хэрэглээг шинэ өндөрлөгт гаргаж ирж мэтгэлцэж чадна тэр нөхрийн тэр барьж байгаа байр суурь заавал шийдвэр гаргах үнэлгээнд орж байх ёстой.

Энэ өнцгөөсөө ч гэсэн юмыг нэлээн тийм шинэлгээр харах тал дээр тал талдаа түвшин түвшиндээ ажиллах ёстой.

Нөгөө талаас өмгөөлөгчид маань ч гэсэн өөрсдийнхөө ур чадварыг, мэдлэгийг, хүний эрхийг хамгийн гол хамгаалж байгаа төрийн бус талаасаа иргэдийнхээ эрхийг хамгаалаад явж байгаа гэдэг үүднээсээ Та нар бас ур чадвараа өөр түвшинд гаргаж ажиллах ёстой шүү.

Ингээд дараагийн асуудалдаа оръё.

**Хоёр. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай
хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**
*/Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/*

Засгийн газар 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг хийе.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал,

дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх

тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон нэгдсэн хуралдааны анхны болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг байгуулсан.

Манай Хууль зүйн байнгын хорооны 5 гишүүнтэй.

Мөн энэ ажилд мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсэг ажилласан.

Ажлын дэд хэсэгт голчлох үүргийг Улсын дээд шүүхийн Иргэний танхимийн тэргүүн шүүгч Г.Алтанчимэг, шүүгч Н.Баярмаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Г.Эрдэнэбулган, М.Цолмон нар орж ажилласан шүү.

Ер нь Засгийн газраас нэг зүйлтэй хуулийн төсөл орж ирсэн. Тэрийг бид үндсэнд нь тэр чигээр нь. Гэхдээ процессын шинж чанартай заалтууд нэлээн нэмсэн. Нэмэхээс ч өөр аргагүй юм билээ. Яагаад гэвэл иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд тусгай процесс, тусгай дэг орж ирж, журам орж ирж байгаа учраас.

Ингээд энэ хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар хийхэд Их Хурлын дарга, хурал даргалагчаас чиглэл өгсөн.

Энэ дотор орж байгаа процессын нэмэлтүүдээс гадна агуулгын шинж чанартай нэмэлт, өөрчлөлтүүдийг хууль санаачлагч буюу Засгийн газар дэмжиж байгаа эсэх талаар тодруулга аваадхаач ээ гэсэн.

Тэгээд өчигдөр ажлын хэсэг дээр Хууль зүй, дотоод хэргийн яамны албаны хүмүүс оролцоод ажлын хэсгээс бэлдсэн,

Байнгын хороогоор дэмжигдсэн, нэгдсэн хуралдаанаар эхний хэлэлцүүлэг нь хийгдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол дээр хууль санаачлагч эсэргүүцэж байгаа зүйл байхгүй. Дэмжиж байгаа.

Тийм учраас бэлдсэн томьёоллын саналыг эцсийн хэлэлцүүлэгт оруулах нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн учраас энэ хэлэлцүүлэг үндсэндээ ингээд эцэслэгдэж байгаа юм.

Тийм учраас ажлын хэсгээс бэлдсэн энэ саналыг дэмжиж өгөхийг хүсье.

Зүгээр процессоороо, дэгээрээ яаж явах юм. Би сайн мэдэхгүй байна. Дахиж бүгдийг нь унших юм уу, эсвэл шууд алх тогшоод явах юм уу. Тэрийг нь би мэдэхгүй байна.

Ер нь агуулгын хувьд эхний хэлэлцүүлгээс нэг их зарчмын өөрчлөлт гараагүй.

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч Н.Баярмаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн шинжээч М.Цолмон.

Танилцуулгатай холбогдон асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байхгүй байна.

2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны үеэр хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Энэ дээр зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Тэрийгээ би гүйцээгээд уншаад явчихъя даа.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулгын хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1, 2 дугаар зүйл болгох:

“1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай Долдугаар¹ бүлэг нэмсүгэй:

“ДОЛДУГААР¹ БҮЛЭГ
Тусгайлсан журмаар хянан
шийдвэрлэх ажиллагаа

75¹ дүгээр зүйл.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг

75¹.1.Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75¹.1.1.бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах;

75¹.1.2.дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах;

75¹.1.3.хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах;

75¹.1.4.бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах.

75¹.2.Дараах нэхэмжлэлийг үнийн дүнгээс үл хамааран шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75¹.2.1.шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол;

75¹.2.2.энэ хуулийн 75¹.1.1-д заасан гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл;

75¹.2.3.ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл.

75¹.3.Эрх зүйн нэг маргаанаас үүдэлтэй шаардлагыг хэд хэдэн нэхэмжлэлээр хэсэгчлэн гаргахыг хориглоно.

75¹.4.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон журмын дагуу шийдвэрлэнэ.

75¹.5.Гэр бүл, өв залгамжлалын холбогдолтой бүх төрлийн хэрэгт тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам үйлчлэхгүй.

75² дугаар зүйл.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх зарчим, хугацаа

75².1.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим баримтад тулгуурлан шийдвэрлэнэ.

75².2.Зохигч шүүх хуралдаанаас өмнө, энэ бүлэгт заасан хугацааны дотор өөрийн шаардлага, татгалзлын үндэслэл болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.

75².3.Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

75².4.Энэ хуулийн 75².3-т заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.

75³ дугаар зүйл.Хэрэг үүсгэх, нэхэмжлэл гардуулах

75³.1.Шүүгч энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасан шаардлага хангагдсан бөгөөд энэ хуулийн 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

75³.2.Энэ хуулийн 75⁴ дүгээр зүйлд заасны дагуу хариуцагчид мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ нэхэмжлэлийн хувийг хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын хамт илгээнэ. Хэрэв мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь, эрх, үүргийн тайлбарыг баталгаат шуудангаар илгээсэн, эсхүл шүүхийн

ажилтнаар биечлэн хүргүүлснийг энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу хариуцагч хүлээн авсан бол ийнхүү хүлээн авсан өдрөөр, энэ хуулийн 75⁴.4-т заасны дагуу хүргүүлсэн бол мөн зүйлд заасан мэдэгдэх хуудас хүлээн авсанд тооцох өдрийг нэхэмжлэлийн хувийг гардаж авсан өдөр гэж үзнэ.

75³.3.Нэхэмжлэл, хариу тайлбар, хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын загварыг Улсын дээд шүүх батална.

75⁴ дүгээр зүйл.Мэдэгдэх хуудсыг хүргүүлэх

75⁴.1.Шүүх энэ хуулийн 77.2-т заасны дагуу мэдэгдэх хуудсыг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол хариуцагч иргэний болон хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар, эсхүл регистрийн дугаарыг мэдээлсэн нэхэмжлэлийн тухайд албан ёсны хаягийг улсын бүртгэлийн байгууллагаас тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа хийнэ.

75⁴.2.Энэ хуулийн 75⁴.1-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагаас тодруулж ирүүлсэн хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол иргэн, хуулийн этгээдтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний, эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээнэ.

75⁴.3.Энэ хуулийн 75⁴.2-т заасан цахим шуудангийн хаягаас гадна

хариуцагчийн албаны болон хувийн цахим шуудангийн хаягийн мэдээллийг нэхэмжлэлд тусгасан бол эдгээр хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг давхар илгээнэ.

75⁴.4.Энэ хуулийн 75⁴.2, 75⁴.3-т заасны дагуу цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш 7 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцно.

75⁵ дугаар зүйл.Хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, гуравдагч этгээд оролцох

75⁵.1.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэгтгэх, тусгаарлах, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд, хамтран нэхэмжлэгч, хамтран хариуцагч татан оролцуулах ажиллагаа хийгдэхгүй.

75⁵.2.Хариуцагч нэхэмжлэлийг гардаж авснаас хойш 7 хоногийн дотор сөрөг нэхэмжлэл гаргаж болно.

75⁵.3.Сөрөг нэхэмжлэл энэ хуулийн 73, 75¹ дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

75⁵.4.Зохигч үндсэн ба сөрөг нэхэмжлэлийг гардан авснаас хойш 5 хүртэл хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй.

75⁵.5.Нэхэмжлэгч иргэний хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасан шаардлага, үндсэн нэхэмжлэлд заасан үндэслэлийн хүрээнд нэхэмжлэлийн шаардлагаа нэг удаа нэмэгдүүлж болно. Нэхэмжлэлийн шаардлагыг

нэмэгдүүлснийг хэргийн оролцогчид мэдэгдэнэ.

75⁵.6.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдын эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр оролцож болно.

75⁶ дугаар зүйл.Гэрчийн мэдүүлэг

75⁶.1.Гэрч энэ хуулийн 43.3-т заасан эрх, үүргийг ойлгосны үндсэн дээр үнэн зөв мэдүүлснээ илэрхийлэн, нотариатаар гэрчлүүлсэн мэдүүлгийг шүүхэд ирүүлсэн нь хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75⁶.2.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн тусламжтай гэрч, шүүгч, зохигч нэгэн зэрэг холбогдон авсан гэрчийн мэдүүлгийг хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75⁶.3.Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлсэн нь гэрчийн мэдүүлгийг энэ хуулийн 75⁶.2-т заасны дагуу үнэлэхэд саад болохгүй.

75⁷ дугаар зүйл.Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэх

75⁷.1.Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш дараах нөхцөл байдал тогтоогдвол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай захирамж гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ:

75⁷.1.1.нэхэмжлэл гаргах, эсхүл иргэний хэрэг үүсгэхдээ энэ

хуулийн 75¹ дүгээр зүйлд заасныг зөрчсөн;

75⁷.1.2. тухайн хэрэг нь эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байж болзошгүй гэж үзсэн.

75⁷.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй.

75⁷.3. Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс тогтоосон тов ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хүчинтэй хэвээр байна.

75⁷.4. Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр үргэлжлүүлсэн нь хэрэг хянан шийдвэрлэх хугацааг шинээр тоолох үндэслэл болохгүй.

75⁸ дугаар зүйл. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх

75⁸.1. Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш энэ хуулийн 74.1-д заасан үндэслэл бүрдвэл хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэнэ.

75⁹ дүгээр зүйл. Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр

75⁹.1. Энэ хуулийн 75⁷.1-д зааснаас бусад тохиолдолд шүүх энэ хуулийн 75¹.1, 75¹.2-т заасан хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх хуралдаанаас шийдвэр гаргана.

75⁹.2. Энэ хуулийн 75⁹.1-д заасан шийдвэр нь удиртгал, үндэслэх, тогтоох хэсэгтэй байх бөгөөд үндэслэх хэсэгт нэхэмжлэлийн шаардлага, татгалзал,

шийдвэрийн үндэслэлийн товч агуулгыг дурдана.

75⁹.3. Шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ хуулийн 119 дүгээр зүйлд заасны дагуу зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулна.

75⁹.4. Энэ хуулийн 75⁹.2 дахь хэсэг давж заалдах шатны шүүхийн магадлалд нэгэн адил үйлчилнэ. Шийдвэр, магадлалын бүтэц, боловсруулах аргачлалыг Улсын дээд шүүх батална.

75¹⁰ дугаар зүйл. Шүүхийн шийдвэрээр нэмэлт хугацаа тогтоох, хуваарь гарган хэсэгчлэн төлөх

75¹⁰.1. Нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн, эсхүл хэсэгчлэн хангасан бол хариуцагчийн санхүүгийн байдал, харгалзвал зохих бусад зайлшгүй шалтгаанаар, хариуцагчийн хүсэлтэд үндэслэн шийдвэрийг биелүүлэх нэмэлт хугацаа тогтоох, эсхүл хуваарийн дагуу хэсэгчлэн төлөхөөр шүүхийн шийдвэрт зааж болно. Нэмэлт хугацаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш зургаан сараас илүүгүй байна.

75¹¹ дүгээр зүйл. Давж заалдах гомдол гаргах

75¹¹.1. Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 75⁹.3-т заасны дагуу гардуулснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

75¹¹.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Ц.Мөнх-Оргил, Н.Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд. Цаашид ажлын хэсэг гэх.

Санал хураалт. Дэмжье гэсэн томьёоллоор явуулья. /алх цохив/

53.8 хувиар санал дэмжигдэж батлагдлаа.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулна.

Дараагийн асуудалдаа орё.

Гурав. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/

Гуравдугаар асуудал. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн [1 дүгээр зүйл](#)-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналгүй болно.

Хуулийн төслийн [2 дугаар зүйл](#)-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналгүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулья.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулна.

Дараагийн асуудалдаа орёе.

**Дөрөв. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

“Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү?

Ш.Раднаасэд гишүүн үг хэлэх үү? Асуулт уу? Тийм ээ. Асуулт Ш.Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Яах вэ, энэ дээр бас зарим зүйлүүдтэй нь санал нийлж байгаа, зарим зүйлүүдтэй нь санал нийлэхгүй юмнууд байгаа.

Яг Их Хурлаас ингээд процесстой холбоотой ч юм уу эрүүгийн хэрэгтэй холбоотой зарим зүйл дээр шууд тусгайлан ингэж чиглэл өгөх нэг талдаа хор ихтэй шүү.

Бодит амьдрал дээр зөвхөн нэг, хоёр кэйс мэдэж байгаа. Энэ дээр л бид гарч байгаа тооцоо судалгаа гэж юм энд албан ёсоор хийгдэхгүй байгаа.

Жишээлбэл, мөрдөн байцаагчгүй бол гэрчийн мэдүүлгийг шууд зогсооно ч гэнэ үү, юу гэнэ вэ. Юу гэлээ. Өмгөөлөгч авахгүй бол гэрчийн мэдүүлэг авахгүй

байх ч гэнэ үү нэг иймэрхүү янз янзын юмнууд яваад байна.

Тэгээд энэ Үндсэн хууль дээр чинь хүн өөрөө өөрийгөө өмгөөлж болно гээд биччихсэн байгаа. Гэх мэтчилэнгээр хуультай нь зөрчихсөн ганц нэг заалтууд энд тэндээс цуглараад орчихсон байгаа шүү.

Миний асуух юу байх вэ, хэлэх гээд байгаа юм. Үүнийг 3 сарын 15-нд боловсруулж оруулж ирэхдээ ялангуяа шүүх, прокурорынхон жоохон түлхүү харж, энд яг өнөөдөр байгаа нөхцөл байдалдаа л тааруулж.

Энд бичсэнээр биш, өнөөдөр байгаа нөхцөл байдалдаа тааруулж засаж авчрахгүй бол яг энд бичсэнээр детальчлаад хийчих юм бол наадах чинь их олон юман дээр гажуудал үүсэх вий дээ гэж болгоомжлох үүднээс үүнийг хэлж байгаа юм шүү. Болгоомжлох үүднээс.

Үүний цаана бид хүний эрх, хүний эрх л гээд байдаг. Яг хүний эрхээ бас сайн хангаж чадаж байна уу, үгүй юу. Тэр нөгөө хэргийн хорьдог хугацааг тусгайлан тусад нь тоолно гээд л ингэхээр дахиад л хязгааргүй хорих нөгөө л хэмжээ рүүгээ бид буцаад л явж байна шүү дээ.

Тодорхой хугацаанд хорьж шалгаад дуусгаад л, дуусахгүй бол гаргаад суллах, явуулах ёстой байтал.

Гэх мэтчилнээр энэ юмнууд энэ дотор их байгаа. Одоо ингэж бичүүлж, бүр ингэж бич гэж яг бараг ингээд тэддүгээр зүйлийн тэд гээд урд талд нь бараг дугаар, зүйл, заалт бичихэд л бэлэн болгож ингэж хийх нь бас зөв байсан уу. Байнгын хорооны гишүүд бас бодох ёстой байх.

Тэгээд одоо хангалттай сэжиглэх үндэслэл байгаа бол гэрч гэж тооцохгүй шууд мэдүүлэг авахыг зогсооно гээд. Ялгаагүй нөгөө л хүний эрхийг бас дахиад л дордуулчхаж байгаа шүү дээ.

Гэрчээр гэж мэдүүлэг өгөх үү, сэжигтнээр, яллагдагчаар гэж мэдүүлэг өгөх үү гэдэг чинь. Ялгаагүй л тийм нөхцөл байдал руу. Бүх юм хоёр талтай. Үүнийг чинь тэгээд жин бангийг нь тааруулна гэдэг чинь яг л мэргэжлийн юм л байхгүй бол.

Энэ бол болгоомжлох юм надад их л байна.

Тэгээд үүний гор ч тэгээд 2024 оны 8, 9 сараас нааш харагдах байх л даа. Наана нь бид энэ хууль ороод, түүн дээр нь хийсэн өөрчлөлтүүд ороод, мөрдөөд тэрнийх нь үр дүн, зовлон жаргалын л одоохондоо энэ дээр бичсэнээр мэдэгдэхгүй шүү дээ.

2024 оны наадмын дараа л энэний юмыг л бид харах байх даа л гэж харагдаж байна.

Тэгэхээр бодвол энэ шүүх, прокурор Хууль зүйн яаман дээр дахиад ажлын хэсэг гарах байлгүй. Үүнийгээ яг мэргэжлийн чиг баримжаа талаасаа харж хуульд нийцүүлж бичээрэй л гэж хэлэх гээд байгаа юм. Миний санаа бол.

Д.Цогтбаатар: Санал байв уу? Бас асуулт гэж ойлгож болохоор ч юм шиг.

Би зүгээр яах вэ, энэ дээр Хүний эрхийн комиссын Б.Энхболд гишүүнийг энэ дээр нэг тайлбар өгөх нь зөв байх гэж би бодож байна.

Тэгэхээр өмгөөлөгчид ч гэсэн Та нар энэ дээрээ.

Тэгвэл ингэе. Энэ асуултаа яагаад, үг хэлэх дээрээ Та нар энэ юмнуудаа хэлээд явчих. Тэгэх үү.

Ш.Раднаасэд гишүүн нэмээд асууя. Тэгэхдээ нэмээд асууя гэхээр хариултгүй ахиж би нэмж асуулгах гээд байна шүү дээ.

Тэгэхээр ингэе. Асуулт асууж дууслаа. Одоо үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Б.Энх-Амгалан гишүүнээр хаалаа.

Ц.Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа.

Энэ тогтоолын төслийг манай Хууль зүйн байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсэг, ажлын дэд хэсгийнхэнтэй ярьж байж боловсруулсан юм.

Энэ цаг хугацааны хувьд 03 сарын 15-ны дотор гэдэг их давчуу байгаа юм. Үнэн үнэн.

Тэгэхээр би Байнгын хорооны даргыг тогтоолыг эцэслэж уншаад батлахдаа хугацааг нь хасчихвал яасан юм бэ гэдэг саналтай байна. Тийм.

Тэгээд Б.Энхбаяр сайд нэн яаралтай оруулж ирэх юмаа 3 сарын 15-даа багтаагаад, заримыг нь 4 сарын 15-даа багтаагаад тэгээд ганц нэг асуудлууд нь хаврын чуулганаас орж ирэх байх.

Энэ дээр гишүүд үг хэлэхдээ хугацааны хувьд саналаа хэлээч.

Хоёрт, энэ тогтоолын 2 дугаар заалт ийм заалт орж ирж байгаа юм.

Эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүх гэж.

Засгийн газраас оруулж ирсэн Шүүх байгуулах тухай хуульд оруулж ирсэн шүүх нь болохоор Гэр бүл, хүүхдийн асуудлаарх шүүх болчхоод байгаа юм.

Тэр нь болохоор хүүхэд өөрөө гэмт хэрэгт холбогдсон биш, гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хэрэг нь шүүгдэгдэж байгаа биш, өөрөө шүүгдэж ч байгаа, хэрэгт ч холбогдсон, эсвэл хохирогч болсон, бүх л асуудлууд нь хүүхэдтэй л холбоотой бол бүх асуудал тийшээ явчих гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр жоохон ялгаатай байгаа юм. Үүнийг тэгж тайлбарлаад үлдээчихмээр байгаа юм.

Энэ тогтоолын төслийн 1.7 дээр шинээр нэгтгэсэн хэрэгт цагдан хоригдсон хугацааг тусад нь тоолох журмыг боловсронгуй болгох гэдэг санал орж ирж байгаа юм.

Энэ ажлын хэсгийн хурал дээр нэлээн асуудал дагуулсан.

Сая Ш.Раднаасэд гишүүн ч гэсэн хүний эрхийг дордуулах чиглэлтэй заалт байна гэж хэлж байгаа юм.

Тэгээд энэ бол ийм юм байгаа юм шүү. Гишүүд ээ. Одоо ерөөсөө бодит практик дээр яадаг вэ гэхээр нөгөө архаг

гэмт хэрэгтнүүд нэг хэрэг хүлээгээд л, тэгээд л цагдан хорих хугацаа нь дуусах.

Тэгээд хэрэг нь шүүх рүү дөхөөд ирэхээр дахиж нэг хэрэг өөр дээрээ нааж аваад л. Тэр хооронд нөгөө цагдан хорих хугацаа нь дуусчхаад байгаа байхгүй юу. Нөгөө эхний хэрэг дээрээ.

Дараагийн хэргээ хүлээчихээр тэр хэрэг нь дахиад очоод нэгтгэгдээд явдаг.

Тэгэхээр цагдан хорих хугацаагүй болчхоод байдаг. Тэгээд үүнийг далимдуулж. Одоо манай Эрүүгийн процессын хуулийн нэгтгэхгүй, өмнөх хугацаагаар явна гэсэн заалтаасаа болоод хуулийн цоорхой ашиглаад байгаа маш их тохиолдлууд байгаа гэж манай шүүхийнхэн ч, хууль хяналтын байгууллагынхан ч гэсэн тайлбар. Ер нь практик дээр тийм юм байгаа л даа.

Тэгээд үүнийг нэг тийш нь болгож байгаа юм шүү.

Энэ бол Ш.Раднаасэд гишүүн ээ, архаг, мэргэшсэн олон хэрэгт зэрэг шалгаж байгаа хулгайч нарт л зориулсан заалт байгаа юм.

Үүнийг тэгээд шаардлагатай бол манай ажлын дэд хэсгийнхэн илүү тайлбарлаад өгчих байх. Тухайлбал, Б.Батцэрэн шүүгч үүнийг тайлбарлаад өгчих байх. Шаардлагатай гэвэл.

Д.Цогтбаатар: Ц.Мөнх-Оргил сайдын энэ асуудал дээр Б.Батцэрэн гишүүн гүйцээгээд.

Яагаад гэвэл хүний эрхийн асуудал яригдаж байгаа бол. Тэгээд хүний эрхийг рецедив гэмт хэрэгтэн байсан ч тэр хүн чинь хүний эрх нь тэр хүнд үйлчилж л байгаа.

Тэгэхээр энэ дээр та нэмээд тайлбарлах нь зөв байх.

3 дугаар микрофон өгье.

Б.Батцэрэн: Та бүхний өдрийн амгаланг айлтгая.

Улсын Дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн.

Ц.Мөнх-Оргил гишүүний хэлсэн дээр нэмж тайлбар хэлье.

Тэгэхээр эрүүгийн хэргийг хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүн байдаг. Эсвэл нэг гэмт хэргийг хэд хэдэн хүн хамтран үйлдэх тохиолдлууд байдаг. Энэ тохиолдолд хэргийг нэгтгэн шийдвэрлэх, эсвэл тусгаарлан шийдвэрлэх зохицуулалтууд бий.

Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүний хэргийг нэгтгэн шийдвэрлэж нэг тогтоолоор хэргийг шүүхийн тогтоолоор шийдвэрлэх нь тэр хүний эрх зүйн байдалд ашигтай байдаг.

Тусгаарлан шийдвэрлэх тохиолдолд эерэг болон сөрөг талууд бий. Тухайлбал, хуулийн шалгуур нь энэ хэргийг бүрэн бодитой шалгаж тогтооход саад учруулахааргүй байвал хэргийг тусгаарлан шийдвэрлэхийг зөвшөөрсөн.

Тэгэхээр яг практикт хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүний хэргийг нэгтгэн шалгах тохиолдолд тэр эхний гэмт хэргийн цагдан хоригдсон хугацаагаар нийт хэргийн цагдан хоригдсон хугацааг тоолно.

Тэгэхээр одоо Эрүүгийн процессын хуульд оруулж байгаа нэмэлт өөрчлөлтөөр цагдан хоригдох нийт хугацааг богиносгочихсон.

Тэгэхээр шинээр илэрсэн хэргийг нь одоо ингээд шалгах гэхээр хорьж мөрдөх боломжгүй нөхцөл байдал үүсэхээр байгаа.

Тэгэхээр шинээр илэрсэн хэрэг дээр цагдан хоригдох хугацааг тусад нь тоолох ийм зохицуулалтыг бий болгосноор хэрэгт холбогдсон хүн бүх хэргээ нэг мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд шүүхийн нэг тогтоолоор шийдвэрлүүлэх сонирхлууд бий болно. Хэргээ хүлээх, хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааныхаа эрх ашиг талаас энэ чухал ач холбогдолтой заалт гэж харж байгаа.

Д.Цогтбаатар: Тэгээд энд Ш.Раднаасэд гишүүн ээ, бас боловсронгуй болгох гээд.

Үүнийг тэгэхээр гүйцэд. Одоо ингээд та бол өөрийнхөө зүгээс барих бодлогыг танай шүүхээс энэ асуудлыг боловсронгуй болгоход барих бодлогоо ярьж байна шүү дээ.

Б.Энхболд гишүүн хэлэх хэлэх юм байна уу? Энэ дээр. Хүний эрхийн комиссын. 2 дугаар микрофон.

Б.Энхболд: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд энэ 7 дугаар заалтыг бас нухацтай авч үзэх шаардлагатай. Энэ бол хүний эрхийг бас зөрчих эрсдэлтэй. Яг өнөөдрийн тайлбарлаж байгаагаар бид их аятайхан ингээд тайлбарлачхаж болно.

Гэтэл практик дээр энэ бол өөрөө бас их олон хэргүүд дээр үргэлжлүүлж нэмж цагдан хорих, нөгөө 18 сарын

хугацаа нь дууссаны дараа үргэлжлэх эрсдэлийг бий болгоно.

Тийм учраас олон улсын гадаад орнуудын Эрүүгийн хууль дээр нэг хэрэгт цагдан хорих дээд хугацаа 2 сар, 3 сар гээд байгаагийн учир нь тэр л юм билээ л дээ. Нэг хэргийг шалгах хугацаа чинь 2 сар цагдан хорих гэж байгаа. Гэтэл манайх дээр яг нэг хэргийг нь шийдэж дуусаагүй байж байтал дахиад хэрэг орж ирдэг.

Тэгээд ингээд явахаар энэ жоохон эрсдэл үүсгэх учраас энэ дээр ажиллах дараагийн ажлын дэд хэсгүүд үнэхээр нарийн сайн ажиллаж өөрсдийнхөө байр суурийг гаргаж хүний эрхийн зарчимд нийцсэн тэр хувилбарыг хэрвээ оруулж ирэх бол тэгж оруулж ирэх нь зөв байх гэж харж байгаа.

Д.Цогтбаатар: Энэ дээр тэгээд өмгөөлөгчид ч гэсэн Та нар санал бодлоо хэлээд явна биз. Ойлголоо.

Г.Амартүвшин гишүүний микрофоныг өгье.

Г.Амартүвшин: Баярлалаа. Яах вэ, энэ тогтоолын төсөл хэрэгтэй ч юм байна.

Гэхдээ яах вэ бас нэг бодох ёстой зүйлүүд ч байна л даа. Яг амьдрал дээр яах вэ ийм хэргүүд чинь яг өөрөөр л явдаг юм билээ л дээ.

Би чинь бас нэг практик туршлагатай хүн шүү дээ.

Яг ингээд л хэрэг PR-ийн давлагаагаар эхлээд л, араас нь тэгээд гэнэт утсаар танаас гэрчийн мэдүүлэг авъя гээд л амралтын өдөр ярина.

Тэгснээ байж байснаа, чив чимээгүй байснаа гэнэт яллагдагчаар татагдсан тогтоол гардуулж өгнө.

Тэгээд процесст болохоор ингээд өмгөөлөгчтэйгөө ороод мэдүүлэг энэ тэр өгөөд, ялангуяа эдийн засгийн санхүүгийн хэрэг дээр шинжээч болон яг мэргэжлийн хүмүүсийн дүгнэлт аягүй чухал байдаг. Хаана ч байсан.

Тэгэхээр яг практик дээр яадаг вэ гэхээр тэр мөрдөж байгаа байгууллага нь шинжээчээ томилж байгаа юм. Түүн дээр нь ингээд санал нийлэхгүй байгаа. Яагаад гэвэл жишээлбэл сонирхлын зөрчилтэй шинжээчийг томилох маш өндөр магадлалтай юм билээ.

Тэгээд дүгнэлттэй нь танилцахаар би мэргэжлийн санхүүч банкирын хувьд үүнээс илүү мэргэжлийн дүгнэлт гаргахаар байгаа байхгүй юу. Тэгээд тэрийг нь маргая, энэ шинжээчээ шинээр томилъё гэхээр ерөөсөө хүлээж авдаггүй.

Хоёрдугаарт, тэр дүгнэлт нь маш олон хуудастай материал. Тэр доороо л танилц. Тэр өрөөнд.

Тэндээс өмгөөлөгч хуулбар авъя гэхээр үгүй болохгүй. Энэ бол нууц. Үгүй ээ, энэ чинь надтай холбоотой хэрэг юм бол би үүнийг чинь аваад ингээд тухтай үзэх надад эрх байгаа.

Тэгэхээр зөвхөн цагдан хоригдохоор хүний эрх зөрчигдөхгүй. Процессын явцад маш олон жижиг ийм хүний эрхийн зөрчил гардаг юм билээ шүү. Би хуульч хүн биш болохоор бас хамаагүй янзан бүрийн юм ярьж байж магадгүй л байх.

Хоёрдугаарт, яг нөгөө Хөгжлийн банкны хэргийг харахад бөөнөөр нь 80-аад хүнийг, хоорондоо ямар ч холбоогүй

хүмүүсийг нэг хэрэг болгочхож байгаа байхгүй юу.

Одоо жишээлбэл би Н.Алтанхуяг гишүүн, сайдтай ямар хамаатай юм. Тийм ээ. Таны хэрэг бол 2012 он, 2013 он. Тийм ээ. Би бол хаа байсан 2019 онд.

Үгүй ээ, тэгээд л шал өөр нөхцөл байдал, шал өөр баримт байхад л бүгдийг нь гээд л ингээд л театрт бүгдийг нь суулгаад л. Одоо ийм юм бас байж болохгүй байхгүй юу.

Тэгээд л тэр чинь ингээд л очер дараалалтай. Хэдэн цаг, хэдэн өдөр, хэдэн сараар сууж байгаа байхгүй юу. Ийм юм бас байж болохгүй ээ. Үүнийг энэ эрүүгийн процесстоо бас тусгах. Зүгээр хүний эрхийг хамгаалах ёстой шүү дээ.

Ер нь тэгээд эцэст нь яг надтай холбоотой тэр Хөгжлийн банкны хэрэг юугаар буруутгаж байна гэхээр нэг л, ганц хоёр хүний зүгээр мэдүүлгээр. Өөр ямар ч нотлох баримт байхгүй. Зүгээр л гэрчийн мэдүүлгээр.

Энэ ингээд тэр гишүүнтэй нь. Дараа нь ингээд харсан чинь телевизийн нэвтрүүлэгт хамт орсон байна. Тийм болохоор найз байх гэж бид бодсон. Дараа нь гэж байгаа байхгүй юу. Намайг ажлаа өгснөөс хойш.

Тэгээд ерөөсөө нэг тиймэрхүү байдлаар ингэж хүнийг нэр хүндийг нь унагааж, одоо бараг хилс хэрэгт ингэж оруулдаг ийм нөхцөл байдал үүсдэг л юм билээ.

Тэгэхээр үүнийг одоо яаж өөрчилж сайжруулах юм. Энэ чинь бас хүний эрхийг зөрчиж л байгаа шүү дээ.

Хэрвээ үнэхээр одоо яг улайм цайм нотлох баримт. Ялангуяа тэр 22.1-ийн хэрэг дээр давуу байдал үүсгээд, бүр ингээд илт юу гэдэг юм хаана ч байхгүй тийм нөхцөлөөр барьцаагүй, бага хүүтэй зээл баталж.

Би тэгэхдээ ганцаараа баталсан биш ч гэсэн тийм нөхцөл байдал бас нэг өөр хэрэг. Аль эсвэл улайм цайм ингээд юм өгч авалцсан байвал бас нэг өөр хэрэг.

Гэтэл өөр баримт байхгүй байхад ингэж юу яаж байх бас ийм байж болмооргүй байна л даа. Нэгд.

Ер нь санхүү, эдийн засаг, банктай холбоотой тэр эрүүгийн хэргүүд маш нарийн мэргэжлийн асуудлууд шүү дээ. Үүнийг дан мөрдөгч, прокурор шийдэх.

Зарим шүүгчид ч гэсэн тийм шийдэх аягүй хэцүү, төвөгтэй хэргүүд. Үнэхээр зээлийн банкны зээлийн процессыг маш сайн мэддэг хүн л үүнийг буруу зөв явсан уу, үгүй гэдэг дүгнэлт хийхээр байгаа байхгүй юу.

Ер нь тэгэхдээ аливаа банкны юм уу, аль нэгэн байгууллагын дотоод дүрэм, журмыг зөрчсөн, зөрчөөгүйг эрүүгийн шүүх шүүдэг нь бас миний бодлоор буруу л гэж харж байгаа.

Тийм болохоор энэ дээр эрхэм гишүүд болон ажлын хэсгийнхэн нэг бодно биз дээ.

Д.Цогтбаатар: Одоо энэ холбогдох хуулийг шинэ нэмэлт, өөрчлөлт гарсантай холбогдуулан боловсруулж оруулж ир ээ гэдэг үүргийг яг Засгийн газарт хэдүүлээ өгч байгаа юм.

Тэгэхээр харин яах вэ хугацаа тавьчихсан байгаа. Тэрийгээ одоо яг ярьж байна.

Б.Энхбаяр сайд энэ гишүүдийн ярьж байгаа юмнуудыг та одоо яг яаман дээрээ эргэж аваад үүнийгээ боловсруулахдаа гишүүдтэйгээ яриарай.

Нээрээ яг амьдрал дээр энэ хүмүүс чинь тэр халуун хүйтнийг мэдрээд арьсан дээрээ мэдрчихсэн хүмүүс байгаад байна шүү.

Тэгэхээр юмнуудаа сайн ярьж авах хэрэгтэй байх.

Ш.Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Миний санал бол энэ хугацааны хэрэг байхгүй байх аа. Нэн даруй гэдэг байдлаар бичээд оруулчих нь зөв байх.

Хоёрдугаарт, тэртээ тэргүй шүүх байгуулах тухай тогтоол явж байгаа юм чинь энэ 2 дээр байгаа тэр хүүхэдтэй холбоотой.

Одоо тэр чинь “тэр бүл, хүүхдийн” гээд нэг тодотголтой яваад байгаа шүү дээ. Түүн дээр чинь яах вэ, хүүхдийнх дээр нэг зовлонтой нь эрүү, иргэн гээд одоо юу байх юм. Бүх л юм хохирогч. Хүүхэд бол эсхүл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хүүхэд бол гэх юм уу.

Түүн дээр л нэг асуудал байгаа юм шиг байна лээ.

Үүнийг харж байгаад түүн дээр нь яаж хийх ёстой юм. Ц.Мөнх-Оргил гишүүн өөрөө ажлын хэсэгт байгаа юм чинь болчих болов уу л гэж бодох юм.

Тэгээд миний санаа бол би энэ зүйл, заалтыг энэ нь буруу, тэр нь зөв гэж

яриад байгаа юм биш. Ерөнхий агуулгаар долоо хэмжиж нэг огтлоорой л гээд байгаа шүү дээ. Гол юм нь.

Одоо Хөгжлийн банкны юмыг сая Г.Амартүвшин ярьж байна. Зүгээр намайг харж байхад иргэний журмаар шийдчихсэн юмыг эрүүгийн журмаар дахиж шүүхээр шийдээд яваад байгаа байхгүй юу даа.

Иргэний журмаар би төлнө, буруутай. Би үүнийг аваад ингээд. Гэтэл эрүүгийн журмаар гээд.

Би одоо тэр зурагтаар шүүх хурлын чинь процессыг ганц нэг харахад тийм юм харагдаж байгаа шүү дээ. Хэчнээн ч тийм хүн байсан юм. Гэх мэтчилэнгээр болж бүтэхгүй засах, цуцлах ёстой юмнууд байгаа бол энэ дотроо хийгээд засаад явах нь зөв л байх.

Гэхдээ зүгээр том агуулгаараа дахиж Их Хурал ингэж яг энэ зүйлийг тэг, тэр зүйлийг ингэ гэдэг ийм тогтоол битгий л гаргаж байгаасай билээ л гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Харин яг үнэн л дээ. Бодит байдал маань л байна.

Б.Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Тогтоолын төслийг дэмжиж байгаа.

Тогтоол батлагдаад гарахаар энэ бол бодлого байгаад байгаа юм.

Ер нь Улсын Их Хурал гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх, хянан шалгах, нотлох, шүүх, шүүн таслах энэ бүхий л ажиллагаанд анхнаас нь хүний эрх хангах энэ зарчмыг гол болгож ажиллана шүү. Энэ чиглэлээр хууль тогтоомжоо

боловсронгуй болгохдоо гол харах өнцөг, нүд чинь энэ шүү гэдэг ийм бодлого, чиглэлийг манай Байнгын хорооноос гаргаж байна гэж ойлгож, талархаж, хүлээж авч байгаа юм.

Тэгээд энэ бол бас өөрөө Засгийн газарт ч гэсэн хууль тогтоомжийг боловсруулах дээр дэмтэй зүйл болно.

Яагаад гэхээр Засгийн газраас, ялангуяа хэргийг илрүүлэх, мөрдөх, шүүн таслахтай холбоотой асуудлуудаар ганцхан Засгийн газар өөрийнхөө бодлогыг гаргаад оруулж ирдэггүй.

Шүүн таслах үйл ажиллагаатай холбоотой асуудлаар шүүхийн хуулиар заавал Монгол Улсын Дээд шүүхийн албан ёсны байр суурь, тайлбарыг авах ёстой. Мөрдөх байгууллагуудын саналыг авах ёстой. Ажлын хэсэгт оруулах ёстой. Олон талын байр суурь байдаг. Өмгөөлөх талын байр суурь орж ирдэг. Тэгэхдээ дандаа нөгөө хүчний хувьд буланд шахагддаг. Нөгөө байгууллагууддаа. Тэгээд санал нь орхигддог, гээгддэг гээд ийм асуудлууд явдаг юм.

Тийм учраас Улсын Их Хурлын тогтоол бидний ажилд бас их тус дэмтэй ийм зүйл болно.

Яг тэр 2 дахь заалтын хувьд дагнасан шүүхийн, өсвөр насны хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүхийн асуудлыг Их Хурлын тогтоолын төслөөс хасвал яасан юм бэ.

Шүүх байгуулах хуулиараа Байнгын хороон дээр энэ асуудлыг судалж үзэж байгаад гэр бүл хүүхдийн шүүхийн харьяалал дээр нэмэх хувилбар, боломж бол байгаа байхгүй юу.

Энэ дагнасан шүүх байгуулах асуудал гэхээр энэ маань нэгдүгээрт

Засгийн газар дангаараа оруулж ирдэггүй. Шүүхий ерөнхий зөвлөл боловсруулаад холбогдох судалгааг нь хийгээд Монгол Улсын Дээд шүүхийн албан ёсны санал авсан хувилбарыг л Засгийн газар уламжилж байгаа юм.

Тэгэхээр Засгийн газар санаачилгаараа нэгдүгээрт Их Хурал үүрэг өгсөн гээд байгуулах бололцоо байхгүй байгаа юм. Шүүх байгуулах хуулиар. Шүүхийн хуулиар энэ нь боломжгүй байгаа юм

Хоёрдугаарт, яг дагнасан шүүх гэхээр чинь энэ чинь аягүй их зардал нь мөнгөтэй хамаатай юм болно.

Бүх аймаг, сумдад яг өсвөр насны хүүхдийн хэргийг шийддэг шүүгч нартай болно.

Доор хаяж эрүүгийн 5 шүүгч гарна. Энэ дээр. Тэгээд 21 аймагт 5 шүүгч гэхээр чинь нийслэл, дүүрэг гээд ярих юм бол энэ чинь 200-аад шүүгчийг шинээр орон тоо нэмэх тухай яриад байгаа байхгүй юу. Энэ ганц заалтын цаана.

Тэгээд энэ бол гарч байгаа хэргийн нөхцөл байдал, тоо хэмжээ аваад өгөхөөр яг ийм чиглэлээр дагнах бол би одоо дээд шүүх ч гэсэн би бол ийм итгэл үнэмшил байхгүй. Энэ тооцоо судалгаа ч байхгүй байгаа байх гэж бодож байна.

Хэргийн гаралт нь цөөхөн байхгүй юу. Нийт гэмт хэрэгтээ гардаг. Харин энэ залилангийн чиглэлээр юм уу, малын хулгайн чиглэлээр дагнасан шүүх гэвэл харин их ачаалалтай. Ийм хэрэг шийдээд байдаг шүүхүүд гарна. Ер нь бол.

Яг энэ өсвөр насны хүүхдийн хэрэг үйлдсэн шүүхээр дагнасан шүүх гэхээр чинь яг энэ хэргийг шийддэг 200 шүүгч гарна.

Тэгээд манай улсад энэ чинь жилдээ 20 гаруй хэрэг үйлдэгддэг байх юм бол энэ шүүх чинь нэг тийм баахан хийцгүйрсэн шүүгч нар гараад ирнэ шүү дээ. Хөдөө.

Тэгээд морь, мал уядаг. Чөлөөт цагаараа шүүгчийнхээ ажлыг хийдэг нэг сонин амьдралгүй юм болчихно шүү дээ.

Захиргааны хэргийн зарим шүүгч нар шиг болчихно шүү дээ. Тийм. Жилдээ 3 хэрэг шийддэг шүүгч байгаа байхгүй юу. Хөдөө.

Тэгээд бүр малчин болчихсон, уяач болчихсон, алдарт уяач болчихсон. Тэгээд улиралд нэг хэрэг шийддэг шүүгч чинь одоо бүр амьдрахын эрхээр хийцгүйрсээр байгаад тийм болчихсон байгаа байхгүй юу.

Тэгэхээр тийм шүүгч болчих вий гэдэг болгоомжлол байгаа юм.

Д.Цогтбаатар: Шүүх рүү хөндлөнгөөс дайраад байна уу, үгүй юу. Энэ чинь бас болж байна уу, үгүй юу. Баримттай юм ярихгүй бол.

Б.Дэлгэрсайхан гишүүний микрофоныг өгье.

Б.Дэлгэрсайхан: Би Хууль зүйн сайдыг тогтоолын төслийг талархан дэмжиж байгаа гэдэгт Хууль зүйн сайддаа талархаж байна.

Яагаад гэвэл хүний эрхийг хамгаалах асуудал дээр нэлээн анхаарч өгөхгүй бол нэг талыг хэтэрхий бариад. Тэгээд энд юу хэлэх гээд байгаа юм гэхээр ер нь өмгөөллийн оролцоо, хэргийг анхан шатаас нь эхлээд оролцоог нь хангахгүй болохоор ерөөсөө явж явж байгаад нэг хэрэг боогоод л хамгийн

сүүлд юу байгааг нь ч мэдэхгүй тэгээд хэдхэн цагийн ч юм уу, нэг, хоёр өдөр өгөөд л хүнийг за май, үүнийг ингээд танилц гээд явчихдаг одоогийн практикийг нэг жоохон боловсронгуй болгохгүй бол ингээд ийм юм бас хэвээрээ байгаад байгаа юм.

Тийм учраас одоо нэгэнт Улсын Их Хурлын тогтоолоор үүрэг чиглэл өгөгдөж байгаа болохоор энэ дээр тэр тэгш оролцоо, хүнийг яллах, өөрийгөө хамгаалах, ялангуяа өмгөөллийн тэр эрхийг нь хангах тал дээр илүү дараагийн хуульдаа тусгаж оруулж ирэхэд анхаарч өгөөч ээ.

Тэгэхгүйгээс болоод хэтэрхий нэг талыг барих юм бол бас хүнийг хэлмэгдүүлэх нэг ийм асуудал.

Хоёрдугаарт, 7-оод байгаа шинээр нэгтгэсэн хэрэгт цагдан хоригдсон хугацааг тусад нь тоолох гээд. Энэ жоохон буруу л юм биш үү. Би эсвэл буруу ойлгоод байгаа юм уу.

Энэ чинь тэгээд дахиад л удаан хорих хугацаа үргэлжлэх ийм юм чинь бий болгоод өгчхөж байгаа юм биш биз дээ. Яах вэ, архаг гэмт хэрэгтнүүдэд хугацааг нь ингэж байгаа юм, богиносгож өгч байгаа юм гэж харагдаж байгаа ч гэсэн нөгөө талдаа болохоор хүнийг дахиад, хөөе чамд дахиад нэг ийм хэрэг гараад ирсэн гээд ингээд хэлмэгдүүлээд байх юм биш биз дээ гэдгийг бас бодолцоорой гэдгийг давхар хэлье. Баярлалаа. Өөр юмгүй.

Д.Цогтбаатар: Б.Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Б.Энх-Амгалан: “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг дэмжиж байгаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан энэ хуулийн төслийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн боловсруулж, 2024 оны 03 сарын 15-ны дотор оруулж ир ээ гэсэн байгаа юм.

Яах вэ, 03 сарын 15-нд болдоггүй юм бол 04 сарын 15 гэж хугацаа заахгүй бол энэ явахгүй. Хаврын чуулганаар ч явахгүй. Тэгээд хугацаа заагаагүй юм чинь. Тэгээд л хэзээ Засгийн газар өргөн барина тэр үед явна гээд ингээд суучихна.

Тийм учраас үүнийг 04 сарын 15 гэдэг хугацаагаар байсан нь зөв гэж нэгдүгээрт бодож байгаа юм.

Хоёрдугаарт, ингээд бид нэг процесс заах гээд л, нэг амьдрал заах гээд байгаа юм биш л дээ. Бүр аргаа барсандаа л Их Хурал тогтоол харагдаж байгаа юм. Энэ хүрээнд судлаадхаач та нар. Ийм ийм өмгөөлөл талын эрх талыг хангаадхаач, прокурор нь нэг ингээдхээч, мөрдөн байцаагч нь ингээдхээч, шүүх нь нэг ингээдхээч. Үүнийгээ эвтэйхэн боловсруулаад нэг дундын эрх ашгаа хамгаалаад ороод ирээч. Тэгэхгүй бол энэ чинь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөөд байна шүү дээ гэдэг асуудал яригдаад л тогтоол гарч байгаа шүү дээ.

Түүнээс бүгдээрээ мэддэг хуульч нар суучаад ингээд байгаа юм биш.

Тэгээд энд олон кэйсүүд байж байгаа учраас эд нар чинь үзээд ингээд болохгүй байна гээд.

Одоо жишээлбэл хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид нь тэр сэжигтнийг баривчлах болоод бусад

юмтай холбоотой юм нь мэдэгдэхгүйгээр зүгээр ингээд тэрэнд чинь мэдэгдсэн гээд хүнийг аваачиж цагдан хорьж болохгүй шүү дээ.

Эсвэл хэдэн арван хавтсыг нь тавьчихаад чи одоо танилц, чамд өгөхгүй гэж бас болохгүй шүү дээ. Тэр хүн чинь өөрийгөө хамгаалах эрхтэй шүү дээ.

Эсвэл мөрдөн байцаагч нь нэг чиг үүргээ буюу яллах талаа барьж хөдөлчхөөд цагаатгах талыг нь барихгүй бол энэ чинь материалаа гаргаж өгье гэхээр авахгүй яах вэ.

Тэгээд шүүх дээр энэ хавтаст хэргийн хэмжээнд л шүүх шүүх хурлаа хийнэ гэхээр нөгөө цугласан баримтдаа хийхээр тэр хүн буруутай л болж гарч ирнэ.

Тийм учраас шүүх дээр материалаа өгдөг юм хүртэл энэ дээр хийх ёстой байхгүй юу. Нотлох чиг үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд тэр прокурор, мөрдөгчийг яах ёстой юм бэ гэдэг юмаа бид бас бодохгүй бол эх сурвалжаа заагаагүй гэрчүүдийн мэдүүлгээр шүүх рүү материал очоод байгаа гэдгийг л энэ олон гишүүд хэлээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг бид нэлээн сайн юмнуудаа харж шийдвэрлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаандаа тусгах, тал талын л юмнууд орсон байна. Өмгөөлөл талын ч юм орсон, прокурор талын ч, мөрдөх байгууллагын талын ч, шүүх талын ч юмнууд.

Тэгэхдээ энэ дээрээ хүрээндээ та хэд маань нэг судалж байгаад үзчихээрэй гэсэн асуудал яригдаж байгаа.

Хоёр дахь асуудлын хүрээнд, хэрвээ энэ асуудлыг судлан үз гэдэг л заалт байгаа юм. Тэр хүүхдийн юутай холбоотой.

Тэгээд үүнийг судлан үзээд мэргэжлийн үүднээс харахад нэг ийм ийм юмнууд байна, ингээд үүнийгээ яая гэвэл тэгээд л тэр орхигдоод л явна биз.

Энэ дээр заавал тэрийг хасаад яах вэ. Энэ чинь бас юм бодож байгаад л оруулсан тогтоол шүү дээ. Хасаад яах вэ гэдэг ийм л зарчмын байр суурьтай байгаа юм.

Тэгээд үүгээр нь гишүүд маань дэмжээд явчихвал их зүгээр байх. Харин энэ дээр орсон нэг тийм цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаан шинжлэн судлах асуудал.

Цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх асуудлыг боловсронгуй болгох гэдэг бол их чухал шүү. Шүүгчдээ ч амар. Их олон мянган хуудас юм уншаад ингээд сууж байхаар тэдийн тэд дээр юу байлаа гээд л ганц товч дараад л татаад харчихдаг ийм юмнууд байвал шүүгчдээ ч амар байх болов уу гэдэг ийм бас нэг санал байгаа юм.

Тэгээд энэ тогтоолын төслийг дэмжиж байгаа. Тэгээд боловсруулсан ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Д.Цогтбаатар: Ш.Адъяаа гишүүн үг хэлье гэсэн. Ш.Адъяаа гишүүнд үг өгье. Ш.Адъяаа гишүүний микрофоныг.

Ш.Адъяаа: Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулж Улсын Их Хурлын тогтоол гарах юм байна.

Улсын Их Хурлын тогтоолыг зайлшгүй гаргах ёстой гэж ойлгож байгаа.

Энэ эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, хүний эрхтэй холбоотой, шүүх хуралдаануудын үйл ажиллагаатай холбоотой энэ олон оролцогчтой холбоотой, олон удаа шүүх хурал хойшилдог, тэнд өмгөөлөгчдийн оролцооны асуудал гээд өнөөдөр эрүүгийн хэргийг шийдэх шүүхэд хянан шийдвэрлэх тухай харилцаатай холбоотой эрх зүйн зохицуулалт өнөөдөр зайлшгүй шаардлагатай байгаа.

Үүнтэй санал нэг байгаа. Ялангуяа гүйцэтгэх ажиллагаа, мөрдөн шалгах, цахим байдлаар гэмт хэргийн нотлох баримт бэхжүүлсэн асуудлыг өнөөдөр ингэж хуульчлах нь зөв зүйтэй байгаа. Энэ дээр санал нэг байгаа.

Тэр дагнасан шүүх байгуулах асуудлыг нь тэгээд нээлттэй хэлэлцэнэ биз дээ. Засгийн газраас авлигын шүүх оруулж ирээд өнөөдөр хүртэл тэгээд байхгүй л байгаа шүү дээ.

Энэ асуудлыг шийдэх ёстой гэж бодож байгаа.

Гэхдээ хугацааны хувьд заах нь зөв юм уу, буруу юм уу. Би эргэлзэж байна.

Өнөөдөр гэмт хэрэгтэй тэмцэх үүргийг Монгол Улсын хэмжээнд зохион байгуулж байгаа Засгийн газар, түүний Хууль зүйн сайд Б.Энхбаяр үүнийг оруулж ирэх ёс суртахууны эрхгүй гэж Их Хурлын гишүүнүүд үзэж байгаа юм.

Яагаад эрхгүй гэж үзэж байна гэхээр сүүлийн үед олон асуудалд Засгийн газар, Хууль зүйн сайдын

асуудал дээр би их тийм хардалттай, их гомдолтой байгаа. Тийм.

Үүнийг яагаад ингэж хэлж байгаа юм гэхээр Мөрдөн байцаалтын нууцын тухай хууль гэж оруулж баталсан. Энэ дээр “хүн” гэдэг ойлголтыг оруулж ирээд тэр сэтгүүлчид, энэ тэр дээр.

Би үгээ хэлчихье. Б.Энхбаяр аа. Ер нь тийм.

Тэгээд энэ дээр яагаад ингэж байна гэхээр өнөөдөр хууль хэрэгжүүлэх ёстой хүн нь Улсын Их Хурлын дээр 20 тэрбумын хөрөнгөтэй сэтгүүлч байна гэж хэлсэн. Энэ хаанаас. Байгаа. Би гаргаж ирж болно.

Энэ хүний ийм увайгүй асуудал энд хувийн эрх ашиг, хүний эрхийг зөрчдөг асуудлыг энэ хүн оруулж ирэх ёс зүй, эрх байна уу, байхгүй юу гэдэг дээр бид өнөөдөр ардчилсан нийгэм үүнийг ярих ёстой.

Ийм учраас би үүнийг Их Хурлын тогтоолыг дэмжиж байгаа. Гэхдээ үүнийг.

Б.Энхбаяр аа, зүгээр л соёлтой миний үгийг сонсчих. Чи битгий бухимд, битгий сандар.

Энэ бол зарчим шүү. Би чамайг үг хэлж байхад юм ярьдаггүй. Дуугүй л сонсдог.

Яагаад гэвэл ийм учраас энэ асуудлыг ингээд тоо, хугацаа заах нь зөв үү, буруу юу гэдэг дээр би эргэлзэж байна. Энэ тогтоолын төслийг дэмжиж байгаа.

Тийм учраас энэ бол миний шударга шүүмжлэл шүү. Үүнийг би чамд ямар нэгэн намайг ингэж байгаа, тэгж

байгаа гэдэг асуудал дээр би яриагүй шүү.

Энэ бол нөөдөр зарчим шүү. Яагаад гэвэл өнөөдөр хүний эрхийг ярьдаг, шударга ёсыг ярьдаг ийм сэтгүүлч, хэвлэл мэдээллийнх нь өнөөдөр хууль хүчний байгууллага чинь барьж аваад хориод, цагдаад өнөөдөр ийм асуудал газар авсан шүү дээ.

Энэ дээр чи дүгнэлт хийх ёстой. Уурлах юм байхгүй, чи бухимдах юм байхгүй, сандрах юм байхгүй. Энэ бол зарчим шүү. Парламент ёсны зарчим шүү. Б.Энхбаяр аа.

Ярих юм би чамайг ард түмний өмнөөс асуух арван асуулт байгаа. Үүнийгээ би асуух болно. Энэ бол миний эрхийн асуудал шүү.

Д.Цогтбаатар: Гишүүдэд нэг юмыг анхааруулаад хэлчихье.

Энэ бол Хууль зүйн байнгын хорооны хурал. Зарчмын ажлын асуудал ярина шүү.

Би бас хүнд үг өглөө гээд та нарын үг хэлэх эрх чөлөөний төлөө би өөрөө энэ Байнгын хороон дээр сууж байхдаа зогсоно. Тэгэхдээ ажил ярина. Түүнээс бие бие рүүгээ, хувь хүн рүү асуудал ярихгүйгээр зарчмын асуудлаа ярих ёстой шүү гэж хэлмээр байна.

Нөгөө талаас кабинетын гишүүд гишүүн хүн үгээ хэлж байхад тэрийг хүндэтгэж сонсож сур.

Яагаад гэвэл шүүмжлэлгүйгээр. Ер нь засагт шүүмжлэл багадаж байгаа юу л гэхээс энэ үгийг бас тал талдаа сонсож сурах хэрэгтэй.

Тэгэхээр тэрийг нь сонсоод л өнгөрөө. Тэгээд дараа нь хэлэх хариултаа хэлнэ биз.

Н.Алтанхуяг гишүүн үгээ хэлнэ.

Н.Алтанхуяг: Баярлалаа.

Ажлын хэсэг Ц.Мөнх-Оргил гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг, дэд ажлын хэсэг их сайн ажилласан. Би жаахан хошуу нэмсэн.

Тэгээд одоо энэ Г.Амартүвшиний үг хэлснээс болоод би хэлчихлээ.

Уг нь би ажлын хэсгийнхэнтэй нэлээн ажиллачихсан учраас өнгөрөөчихье гэж бодсон юм. Энэ Б.Энх-Амгалан гишүүн.

Дээр үед зэвсэг нэгт ахан дүүс гэж зохиолд байсан юм. Одоо зовлон нэгт ахан дүүс гэдэг ийм зохиол бид нарын амьдрал дээр бодитойгоор бичигдэж байгаа юм.

Тэгэхдээ нэг талаасаа хүмүүст зовлон тохиолдож байгаа боловч нөгөө талаасаа Монголын хууль хяналтын байгуулага дахь болохгүй байгаа хууль журам, дэг журам, үүнтэй холбоотой юмнуудыг өөрчлөхөд бид бас хувь нэмрээ оруулах ёстой. Тийм үүрэг, хариуцлага бид нар дээр ирж байна гэж бас нөгөө талаасаа би бодож байгаа юм.

Тийм учраас энд идэвхтэй оролцох ёстой, бид нар. Та нарыг идэвхтэй оролцож байгаад их баярлаж байгаа юм.

Боломжийнхоо хэмжээнд ингээд сайжруулж байгаа. Одоо яг тань шиг нэг өдөр дуудаад л, тэр дээр үеийн хавтаст хэрэг дээр яллагдагчаар татаад л 15 хуудастай яллагдагчаар татагдсан

материалыг шууд уншаад гарын үсэг зур гэж байгаа юм.

Үүнийг чинь яаж амжих вэ дээ гэхээр. Тэгээд гар утсаа оруулж ирээд зургийг нь авчихъя гэхээр. Үгүй ээ. Энэ бол баривчлагдсан яллагдагч дээр байдаг болохоос биш таныг дуудаж ирүүлсэн гээд эхэлсэн байхгүй юу.

Эндээс болоод асуудлыг энэ асуудлыг үүний өмнөх юман дээр зохицуулчихсан.

Яагаад баривчлагдсан гэж бичигдсэнийг нь ч ойлгосон. Ингээд анхнаасаа л ерөөсөө хэн нэгэн хүнийг буруутгаж болно л доо. Хэн нэгэн хүн гэмт хэрэгт холбогдож болно.

Анхнаасаа эрх тэгш харилцмаар байгаа байхгүй юу. Шууд ингээд л 15 хуудас юм унш. Тэгэхгүй бол өмгөөлөгчөөрөө хуулуулж ав гэдэг бол ингээд л тэнгэр газар шиг болгочхож байгаа юм.

Тэгээд энэ бол ерөөсөө шүүхэд шидэгдэх хүртлээ яг ингэж явж байгаа шүү дээ.

Тэгэхээр ийм ийм зовлонгууд нь байгаа учраас үүнийг залруулах гэж манай дэд ажлын хэсэг ч ажилласан, Ц.Мөнх-Оргил гишүүн ч ажилласан, нэлээн ажилласан.

Тэгэхдээ би нэг юм Ц.Мөнх-Оргил гишүүн ээ, бид маш их олон ярьсан. Одоо үүний 4 дээр байгаа ганцхан үгийг солихгүй бол маш муу прецидент үүсчхэж мэдэх л сонсогдоод байна.

4.Олон оролцогчтой хэрэг гээд байгаа юм. Үгүй ээ, та бид хоёр яахаараа хам хэрэгтэн болчихоод байгаа юм. Би бас ойлгохгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ үг ингээд цаашаа явчихвал практик дээр олон оролцогчтой хэргийг бий болгоод байх сонирхол үүснэ, цаашдаа.

Ер нь гучин хэдэн онд л арван хэдэн хүнийг олон оролцогчтой болгож буудсан шүү дээ. Түүнээс хойш байхгүй болчихсоныг гэнэтхэн Хөгжлийн банкн дээр гарч ирсэн юм.

Тэгээд яахаараа 2013, 2014 оны маш их сонин сонин юмаар ингээд холбодог юм билээ.

Тэгэхээр Ц.Мөнх-Оргил гишүүнтэй би нэг юман дээр санал нэг байгаа.

Олон хохирогчтой хэрэг бол болно. Юу гэлээ? Тэр чинь. Нэг англи үг. Класс акт гэдэг юм бий болгоод, тэгээд түүн дээрээ ийм ийм газар, ийм ийм нөхцөлд байсан хүмүүс хохирогч шүү гээд зарладаг.

Одоо энэ ямар сэдлийг өгөөд байгаа вэ гэхээр та бид хоёрыг “хамаг хэрэгтэн” болгоод байгаа байхгүй юу. Үгүй ээ, яаж бид хоёр хоорондоо холбогдох вэ.

Тэгэхээр би “олон оролцогчтой” гэдгийг нь “олон хохирогчтой” болгочихъё. Тэгээд класс актаараа явчихъя.

Үг нь үү? Тэгвэл тэр үгээ сайжруулаарай.

Ер нь үүнээс хойш, түүнээс хойш байна шүү дээ би энэ микрофонд яагаад ярьж байгаа вэ гэхээр манай Хүний эрхийнхэн ч байж байна, манай хууль хяналтынхан байна.

Үүнээс хойш, түүнээс хойш “олон оролцогчтой” гээд “олон гэмт хэрэгтнүүдийг нэгтгэсэн юм шиг” ийм хэрэг дахиж хийгдэхгүй шүү. Монголд.

Сая бид 3 сар сууж байхад тэрийг дотор нь ангилах юм бол хорин хэдэн төрлийн юм байгаа биз дээ. 80 хүнийг хорин хэд хуваахаар 3, 4 хүн л нэг болоод байгаа байхгүй юу.

Тэгэхэд бүтэн 3 сар ингээд Их Хуралд суулгахгүй тэнд аваад суулгаж байгаа юм. Зүгээр л улс төрийн залхаан цээрлүүлэлт хийж байгаа юм.

Ийм ийм юмнуудыг. Би дахиад нэг юман дээр энд оруулж чадаагүй. Та нарт би дахиад үлдээчихье.

Б.Энхбаяр сайд аа, та бас арай наанатай цаанатай ханддаг хүн нэг юм анхаарчих.

“Хэргийг тусгаарлах”, “хэргийг нэгтгэх” гэдэг энэ үйлдэл аягүй их аюултай үйлдэл байгаа байхгүй юу. Энэ прокурор дээр байгаа.

Нүүрсний хэргээр Ш.Гансүхтэй хамт 3 залууг шоронд хорьчихоод, 6 сар шоронд хорьсны дараа тэд нар нүүрсний хэрэгт ерөөсөө яллаагүй. Дуудаа ч үгүй.

Тэгээд гайхаад, яасан бэ гэсэн чинь та нарын хэргийг тусгаарлачихсан. Тусгаарлаж байгаад, Та нар дээр татварын хэрэг үүсчихсэн гэж байгаа юм. Үгүй ээ, энэ одоо тэгээд яаж байгаа юм.

Надад дээр бол. Би дахиад хэлье.

Эхний тогтоол нь “Хөгжлийн банк” гэдэг үг, үсэг байхгүй байна гэсэн чинь тань дээр ер нь таныг нэмж яллагдагч болголоо гээд дахиж нэг тогтоол гаргаж ирчхээд хэсэг хугацааны

дараа энэ хоёрыг нэгтгэлээ гэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл эхний хэрэг чинь хэрэг биш байхад заавал хоёр дахь хэрэг олж байгаа байхгүй юу. Тэр нь бас хэрэг биш шүү дээ.

Тэгээд байхгүй хоёрыг нэгтгэж байгаа байхгүй юу.

Ер нь л аймшигтай юм билээ шүү дээ. Би одоо 30-аад оныг л аймшиг гэж бодож байсан. Бид нар.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Н.Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Би яах вэ, хуучин мөрдөх байгууллага, тэр прокурор дээр нь би нэлээн мэддэг байсан чинь сая би шүүх дээр очоод дахиад асар их хүний эрхийн том зөрчлүүдийг харсан.

Тэгээд л ерөөсөө анхнаасаа чи ямар нэгэн хэрэгт сэжигтэн юм уу, яллагдагч болох юм бол тэгээд л дуусаа. Хавь ойрынх нь чинь, хамаатан садан чинь, үр хүүхэд чинь, эхнэр чинь бүгд зовлонгийн далайд.

Тэгээд үргэлж мөнхийн доошоо хараастай, нэг тийм гэмт хэрэгтэн.

Яагаад гэвэл яг Г.Амартүвшин гишүүний хэлж байгаа шиг хэвлэлээр эхлээд цоллодог байхгүй юу. Хуучин тэр Хурц гэж хулгайчийн үед бүр Авлигатай тэмцэх газар хэвлэлд асар их мөнгө өгдөг байсан.

Ямар ямар сайт дээр юу гарах вэ гэдгийг би урьдчилан мэддэг байсан. Энэ дээр гарсан мэдээ тэд нарын санхүүжилтээр хийгдэж байгаа. Ийм айхтар юм байсан юм л даа.

Тэгээд одоо яах вэ, ингээд би жаахан жаахан зөөлрөх чиглэл рүү нь явуулж байна, ингэж оролдож байгаа.

Тэгэхдээ би сая хэллээ шүү. Б.Энхбаяр сайд аа.

“Тусгаарлах”, “нэгтгэх” гээд.

Ер нь философи нь ингэмээр юм билээ. Хэн нэгэн хүний үзэмжээр шийддэг юмыг шүүх дээр аваачаад л бид цохиулмаар юм билээ.

Тэгэхээр тэрийг энд оруулчихсан шүү дээ. Б.Батцэрэн шүүгч бас ингэсэн. Нотлох баримтыг шүүхэд гаргах эрхийг хуульд тусгах гээд.

1.7.Манай энэ дээр 12-ыг бол ингээд биччихсэн байгаа. Маш олон юмыг бид шүүх дээр очиж заргалдаж байж л явах юм билээ. Тэгэхгүй бол мөрдөгчтэй заргалдаад нэмэргүй, прокурортой заргалдаад нэмэргүй ийм л өнөөдрийн тогтолцоо байгаа юм байна лээ шүү.

Мэдээж яг тэр гэмт хэрэг үйлддэг, олон гэмт хэрэг үйлдэж байгаа бодитой хүмүүс дээрээ бол байдаг л байх.

Улс төрчид дээр бол үүнийг ингэж авч байж хэрэглэдэг юм байна лээ шүү.

Тийм учраас бас чадаагүй юмнууд байгаа шүү гэдгийг би хэлж байгаа юм.

Д.Цогтбаатар: Үүнтэй холбогдуулаад би хэдэн зүйл хэлчихье гэж бодож байна.

Өнөөдөр байгаа хуульдаа, ялангуяа жишээлбэл өмгөөлөгч эд нартай холбоотой хууль дээр эрх зүйн статус юм нь тодорхойлогдсон байж байгаа шүү дээ.

Тэгээд хууль хэрэгжих дээр асуудлууд гараад байгаа юм. Түүнээс их олон юман дээр өнөөдөр эрх зүйн манай тогтолцоо чинь бас нэлээн хөгжчихсөн. Энд яригдаж байгаа зөндөө асуудлууд чинь тусчихсан байгаа шүү. Огт байхгүй, хуульгүй орчин шиг бол биш.

Харин хуулийг хэрэгжүүлэхдээ манай хуулийн байгууллагууд маань нэг зүйлийг анхаарч байх хэрэгтэй.

Одоо жишээлбэл эрүүгийн, иргэний процессын хууль дээр нэг зүйл ороогүй бол яг тэр хуулиа бариад л.

Тэгтэл Монгол Улсын хууль тогтоомж чинь бүхэлдээ өөрөө контекст дээрээ уялдаж тайлбарлах ёстой.

Ялангуяа төрийн зүгээс энэ асуудал дээр хуулиа тайлбарлахдаа өргөн харж, цаад Үндсэн хуулиасаа эхлээд л үүний чинь зорилго агуулга нь эхнээсээ юу билээ. Хүнийг хамгаалахын төлөө. Түүнээс буруутгахын төлөө яваад байгаа юм биш.

Тэр “**presumption of innocence**” гээд “**буруугүйн зарчим**” чинь бүх хүнд үйлчилж байгаа.

Хамгийн нэгдүгээрт шүүгчид үйлчилж байгаа. Шүүгч өөрөө шийдвэрээ гаргах хүртлээ нөгөө хүнийг буруугүй л гэж итгэж байх ёстой.

Тэгэхээр энэ өнцгөөсөө тайлбарлаад эхлэх юм бол одоо хоёр хууль зөрчилдөж байхад тэр хүний эрхийнхээ талд уг нь тайлбарлаад хэрэглээд явж байх ёстой.

Тэгэхдээ амьдрал дээр тэгэхгүй байгаа л даа.

Тийм учраас бид одоо ингээд тогтоол оруулж ирээд илүү тодотгоод явъя гээд. Энэ бол илүү тодотгох, нарийвчилж, боловсронгуй болгох процесс явах гэж байна шүү дээ.

Тэгээд үүнийгээ цаашдаа ч бид мянга нарийвчилж боловсруулаад цаад хандах хандлага, сэтгэлгээ чинь би энэ хүнийг хамгаалах талаасаа явах ёстой шүү гээд. Ялангуяа энэ төрийн байгууллагууд үүнийгээ харж байх ёстой.

Тэгэхээр өнцгөөсөө хуулиа тайлбарлаж явах тэр соёлыг бас хэвшүүлж сурах нь аягүй чухал байгаа шүү. Тэгэхгүй бол тэгээд л өмгөөлөгчтэй чинь ярихгүй.

Яг хэргийн асуудал үүсгэж байгаа тохиолдолд бараг тэр хариуцагчаасаа илүү өмгөөлөгч тухайн хэрэгт илүү статустай шүү дээ. Яагаад гэвэл хариуцаж байгаа хүн үг хэлэхгүй ч байх эрхтэй шүү дээ.

Өөрийгөө тэгээд өмгөөлж чадахгүй гэдгийг нь систем мэдээд өмгөөлөгчид нь давуу эрхийг өгчихсөн байгаад байхад заавал өмгөөлөгчийг нь тойрч.

Яагаад гэвэл өмгөөлөгч нь олон юм яриад мэтгэлцээд байж магадгүй гээд хариуцагчтай нь ажиллах гээд байдаг ч юм уу, ингэж болохгүй. Цаад хандлагын асуудал бас байгаа шүү.

Энэ дээр нэг зүйл хэлмээр байна.

Түрүүн Б.Энх-Амгалан гишүүн чухал юм ярьсан.

Би С.Одонтуяа гишүүнд нэг зүйлийг хэлж байгаа. Ардчилсан намын гишүүддээ.

Энэ хүнийг хилс хэргээр хэлмэгдүүлсэн хүмүүсийг Монголын төр зүгээр үлдээчихсэн юм билээ. 1937 оны юун дээр.

Өнөөдөр татвар төлөгчид 1937 онд гарсан хэргийн хариуцлагыг өнөөдөр бид хүлээгээд хохирогчид нь мөнгө төлөх үү, ямар нэгэн байдлаар тэр хохирлыг нь барагдуулаад яваад байгаа. Хохирогчдыг нь яагаа ч үгүй нэг удаа үлдээсэн юм билээ.

Энэ бол түүх. Энэ ардаа үлдээсэн юм.

Одоо шинээр хууль оруулж ир. Энэ Ардчилсан намынхан Та нар дотроо ярьж байгаад **хэлмэгдүүлсэн хүмүүст хариуцлага тооцдог бол.**

Би эртээд хуульчидтай ярьж байгаад нас барсан байсан ч тэр хүмүүс чинь одоо ингээд баатрын тэмдэгтэй, үр хүүхдэдээ нэг их том баатар болоод яваад байгаа байхгүй юу.

Хүн хэлмэгдүүлсэн бол нас барсан байсан ч асуудлыг нь хэлэлцүүлээд, энэ хүн буруу шийдээд хүн хэлмэгдүүлчихжээ гэдэг шийдвэр гаргах ёстой.

Тэгэнгүүт тэгж байна лээ. Нас барчихсан байхад хэрэг дуусна шүү дээ. Үгүй.

Энэ цагаатгалын комисс дээр чинь нас барчихсан хүмүүсийг цагаатгаад байгаа шүү дээ. Тэгвэл хилс хэрэгт хүнийг хэлмэгдүүлсэн хүнийг дараа нь ч гэсэн гаргаж түүхийн дүгнэлтэд өгвөл энэ чинь түүхэнд хэрэгтэй, үр хүүхдэд хэрэгтэй юм байхгүй юу.

Тэгэхээр үүнийг санаачилж оруулж ирэх ёстой. Би С.Одонтуяа

гишүүнд бас санал болгосон байгаа. Энэ чухал заалт шүү.

Яагаад гэвэл дээр би улс төржмөөргүй байна. Хэн хэндээ сургамж болно. Энэ чинь хэн хэндээ сургамж болох байхгүй юу.

Тэгээд энэ тогтоолын төсөл дээр тэр 04 сарын 15 гэдэг Б.Энх-Амгалан гишүүний зөв байх. Энэ дээр ингээд хугацаатай явах ёстой.

Тэр 2 дугаар зүйл дээр Б.Энхбаяр сайд аа, ингэе тэгэх үү. Энэ чинь нөгөө Нэгдсэн Үндэстний Байгууллагын зөвлөмжтэй юм байна шүү дээ.

Тэгэхээр энэ зөвлөмжийнх нь дагуу та нарыг судлаад л саналаа оруулаад ир гэж байгаа болохоор судлаад л, тэгээд болохгүй бол болохгүй, өөр юмтай Та нар нэгтгэж байгаа бол түүгээрээ оруулаад ир.

Одоо нэгэнт орж ирсэн юман дээр энд ингэж хасаж уншаад хэрэггүй. Судлаад ир гэж байгаа юм чинь тэрүүгээр нь уншаад явъя.

Б.Энхбаяр гишүүний гаргаж байгаа зарчмын зөрүүтэй санал энд орчихсон байгаа болохоор төсөл тараагаад өгчихсөн байгаа. Та өөрөө харчихна биз. Таны санал орчихсон байгаа.

Саяын Ш.Адъяаа гишүүний юун дээр нэг зүйлийг хэлмээр байна.

Ийм амаргүй асуудлууд дээр ялангуяа шүүх рүүгээ. Одоо сүүлийн үед шүүх рүүгээ аягүй их хүмүүс халдаж дайрч ярьдаг болж байна.

Хууль зүйн сайд дээр ч гэсэн сая хяналтын сонголт хийхэд мэдээж хүмүүс дургүйцэж ярьж байгаа.

Тэгэхээр ингэж болохгүй ээ. Бүгдээрээ л тал талаасаа үүнийг хэлэлцэж байгаа. Шүүх ч гэсэн Та нар ингэж шүүмжлүүлж магадгүй, тэгж магадгүй гэж айлгүйгээр Та нар дотоод итгэл үнэмшлээрээ.

Олон нийтэд таалагдахгүй ч шийдвэр гаргаж магадгүй. Та нар хуулийн дагуу л шийдвэр гаргах ёстой. Тэгээд үүн дээрээ зоригтой байх ёстой шүү. Энэ дээр Б.Энхбаяр гишүүн ч гэсэн хүнд ачаа үүрсэн.

Тэгээд ийм тохиолдолд олон хүнд таалагдахгүй байх эрсдэл бий. Ажил төгс биш байж болно. Энэ чинь амьдрал юм чинь.

Тэгээд дараа нь яг хуулийнхаа дагуу зөв, буруугаа бүгдээрээ тогтоолгоод л явдаг ийм зарчимтай.

Тэгэхээр энэ дээр хувь хүн рүүгээ, бие бие рүүгээ тэгж халдаж дайрах нь бас зохисгүй шүү гэдгийг хэлмээр байна.

Б.Энхбаяр гишүүнд энэ дээр ажлаа харин хамгийн мэргэжлийн түвшинд сайн хийгээд явж байгаа гэж итгэж байгаа шүү.

Миний хэлэх зүйл ийм байна. Би энэ тогтоолынхоо төслийг шууд одоо байгаагаар нь уншаад танилцуулчихъя.

Тэгээд санал хураачихъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол.

Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан дараах асуудлыг судлан холбогдох хуулийн төслийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцүүлэн боловсруулж 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, эсхүл түүнээс гэрчийн мэдүүлэг авахгүй байх, гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол гэрчийн мэдүүлэг авахыг даруй зогсоох зохицуулалтыг тусгах;

2/хүний халдашгүй байх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хүрээнд мөрдөн байцаалтыг өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр явуулахгүй байх, хэрвээ өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр мөрдөн байцаалт явуулж нотлох баримт цуглуулсан, хэрэг хүлээлгэсэн тохиолдолд тухайн мэдүүлэг, нотлох баримтыг үнэлэхгүй байх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

3/шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулдаг үндэслэл, нөхцөл боломжийг бий болгож байгаа хуулийн

хийдлийг судалж, түүнийг арилгах, зохицуулалтыг боловсронгуй болгох;

4/олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тогтоохтой холбогдсон зохицуулалтыг хуульд тусгах;

5/хавтаст хэргийг цахимжуулах, цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаанд шинжлэн судлах, цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх журмыг боловсронгуй болгох;

6/төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүх, прокурорын шийдвэрийг оролцогчид танилцуулах, гардуулан өгөх журмыг нарийвчлан зохицуулах;

7/шинээр нэгтгэсэн хэрэгт цагдан хоригдсон хугацааг тусад нь тоолох журмыг боловсронгуй болгох;

8/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах нөхцөл боломжийг бий болгох, 6-аас дээш сар хадгалах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

9/Өмгөөллийн тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх, үүргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмж тусгах;

10/сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон үндэслэлд хамаарах нотлох баримттай танилцах, таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлгийг талуудын мэтгэлцээний үндсэн дээр

явуулах зохицуулалтыг боловсронгуй болгох;

11/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг сайжруулах, хэргийн оролцогчийн эрхийг хангаснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараагийн шатанд хэргийг шилжүүлдэг зохицуулалтыг тусгах;

12/мөрдөгч, прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан яллагдагч, шүүгдэгчийг цагаатгах, хэргийг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг нотлох чиг үүргээ хэрэгжүүлээгүй бол яллагдагч, шүүгдэгч энэ талаарх нотлох баримтыг шүүхэд гаргах эрхийг хуульд тусгах;

13/хүн ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхийг хангах хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан талаарх тогтоолыг гардуулан өгөх зохицуулалтыг хуульд тусгах;

14/шүүх, прокурор, мөрдөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хүсэлтийг хангахаас татгалзаж байгаа үндэслэлийг тухайн шийдвэртээ тодорхой тусгах асуудлыг хуульчлах.

2.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хороо, Эрүү шүүлтийн эсрэг хорооноос гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүхийн тогтолцоог бүрдүүлэх талаар судалж Монгол Улсын Их Хурлын 2024 оны

хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмжтэй холбоотой зардлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

5.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Энэ ингэж уншиж танилцуулсан томьёоллоор дэмжье гэж санал хураалт явуулья. /алх цохив/

83.3 хувиар тогтоолын төслийн санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулья. /алх цохив/

75.0 хувиар санал дэмжигдлээ.

“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин уншина.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 01 цаг 54 минут үргэлжилж, 12 цаг 27 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД